

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗАР

ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2019 ОНЫ 03 ДУГААР УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2019.10.02

Өлгий сум

Нэг: Удирдлага, зохион байгуулалтын талаар:

1.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын болон захиргааны үйл ажиллагааны баримт бичгийн зүйл, заалтын хэрэгжилтийг хэрхэн зохион байгуулж, хангаж буй талаар.

1. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/01 дүгээр тушаалаар баталсан Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2019 онд дэвшүүлсэн зорилт, Цагдаагийн ерөнхий газрын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндэслэж, Цагдаагийн газрын 2019 оны гүйцэтгэлийн 94 заалт бүхий төлөвлөгөөг Цагдаагийн газрын даргын 2019 оны А/01 дүгээр тушаалаар, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2019 онд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх 26 заалт бүхий ажлын төлөвлөгөөг 2019 оны 01 дүгээр сарын сарын 07-ны өдөр баталж, тайлангийн хугацаанд хэрэгжилтийг 94 хувьтай хангав.

2. Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын даргын 2019 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 5/29 дүгээр албан бичгээр ирүүлсэн Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2019 онд хэрэгжилтийг хангах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, биелэлт үр дүнг тооцох баримт бичгийн жагсаалт батлах тухай” энэ оны А/42 дугаар тушаалын үндэслэн Цагдаагийн газрын даргын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/12 дугаар тушаалаар холбогдох баримт бичгийн хэрэгжилт, биелэлт үр дүнг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/189 дүгээр тушаалаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал”, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх /код 110/ журам”-ыг тус тус баримтлан тайлагнаж, тогтоосон хугацаанд холбогдох алба, нэгжид хүргүүлэхийг тасгийн дарга нар болон урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн нарт хариуцуулж, энэ оны 3 дугаар улирлын байдлаар 70 баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнаад байна.

- Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2019 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн “Тушаалын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” А/162 дугаар тушаалаар “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2019 онд хэрэгжилтийг хангах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, биелэлт үр дүнг тооцох баримт бичгийн жагсаалт”-ыг шинэчлэн баталсантай холбоотой Цагдаагийн газрын даргын 2019 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн А/52 дугаар тушаалаар “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2019 онд хэрэгжилтийг хангах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, биелэлт үр дүнг тооцох баримт бичгийн жагсаалт” болон тайлагнаж, тогтоосон хугацаанд холбогдох алба, нэгжид хүргүүлэх алба хаагчдыг шинэчлэн баталсан.

3. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын удирдах ажилтны сургалт, зөвлөгөөний үед Хууль зүй, дотоод хэргийн сайдын өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх 96 заалт бүхий ажлын төлөвлөгөөг 2019 оны 03 дугаар сарын 06-ны өдөр, Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчаас өгсөн үүргийг хэрэгжүүлэх 96 заалт бүхий ажлын төлөвлөгөөг 2019 оны 01 дүгээр сарын

30-ны өдөр, Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргаас өгсөн үүрэг, ажлын чиглэлийг хэрэгжүүлэх 24 заалт бүхий ажлын төлөвлөгөөг 2019 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр тус тус баталж, хэрэгжилтийг хангуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч, хэрэгжилтийг энэ оны хагас жилийн байдлаар гаргаж, Цагдаагийн ерөнхий газрын Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэст 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 27/2489 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

4. Дээд шатны байгууллага, удирдах албан тушаалтнаас ирүүлсэн үүрэг, ажлын чиглэлийг алба хаагч нэг бүрт хүргэх, ялангуяа сумдад үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдад тухай бүрт нь хүргэн судлуулах, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах, үүрэг, ажлын чиглэлийн нэгдсэн бүртгэл хөтөлж баримт үйлдэх, тайлагнах үүрэг бүхий орон тооны бус багийг Цагдаагийн газрын даргын 2018 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/67 дугаар тушаалаар байгуулж, тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар Цагдаагийн ерөнхий газрын даргын 3, Тэргүүн дэд даргын 7, Дэд даргын 25, нийт 35 төрлийн даалгавар, үүрэг, ажлын чиглэл, зөвлөмж, дээд шатны байгууллага, удирдах албан тушаалтнаас ирүүлсэн 85 төрлийн үүрэг, ажлын чиглэлийг алба хаагч нэг бүрт хүргэж, хэрэгжилтийг хангуулж, хэрэгжилтийг тогтоосон хугацаанд хүргэх ажлыг зохион байгуулсны үр дүнд алба хаагч бүрт жигд хүртээмжтэй хүрч, хэрэгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлсэн.

Мөн дээд шатны байгууллага, удирдлагаас ирүүлсэн албан даалгавар, үүрэг, ажлын чиглэл, зөвлөмж, мэдээллийг алба хаагчдад мэдээлсэн, түүний дагуу хэрэгжүүлсэн ажил, үр дүнгийн талаар тусгайлан бүртгэл гарган ажлын баримт үйлдсэн.

5. Цагдаагийн ерөнхий газрын Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтсийн даргын 2019 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 5а/1204 дугаартай албан бичгээр ирүүлсэн тус Цагдаагийн газрын 2018 оны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгч, ирүүлсэн санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор 44 заалт бүхий ажлын төлөвлөгөөг 2019 оны 03 дугаар сарын 04-ний өдөр баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

6. Цагдаагийн ерөнхий газрын нэгдсэн сүлжээ болон бусад байгууллагаас ирүүлсэн 2037 албан бичгийг хүлээн авч бүртгэж, 3825 албан бичиг, мэдээг тогтоосон хугацаанд холбогдох цагдаагийн байгууллагуудад хүргүүлэв.

7. Монгол Улсын Засгийн газраас 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил” болгосонтой холбогдуулан тус Цагдаагийн газраас хэрэгжүүлэх 27 заалт бүхий ажлын төлөвлөгөөг 2019 оны 03 дугаар сарын 15 өдөр баталж, хэрэгжилтийг хангуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч, хэрэгжилтийг холбогдох алба, нэгжүүдэд хүргүүлсэн.

8. Аймгийн Засаг даргын Хууль зүй, дотоод хэргийн сайдтай 2019 онд хамтран ажиллахаар байгуулсан гэрээний хэрэгжилтийг энэ оны хагас жилийн байдлаар 80 хувьтай хангаж, аймгийн Засаг даргын тамгын газарт 2019 оны 06 дугаар сарын 07-ны өдөр 27/2326 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

9. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 11 төрлийн ажил, арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

10. Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх Салбар комиссын дарга, Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны даргын 2019 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 8/904 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Зөвлөмж, ажлын чиглэл”-ийн дагуу Цагдаагийн газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/37 дугаар тушаалаар Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх салбар комиссыг 10 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй байгуулж, бэлтгэл ажлыг хангах 17 заалт бүхий ажлын төлөвлөгөөг баталж, Цагдаагийн газрын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг дүгнэх үзүүлэлт, аргачлалын дагуу урьдчилсан

байдлаар дүгнэж дүнг 2019 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 27/2202 дугаартай албан бичгээр Цагдаагийн ерөнхий газрын Төв архивт хүргүүлэн бэлтгэл ажлыг хангасан.

Цагдаагийн газрын албан хэрэг хөтлөлтийг сайжруулах, тогтоосон стандарт, заавар, журмыг алба хаагч бүрээр судлуулах, мөрдөж хэвшүүлэх зорилгоор Цагдаагийн газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/42 дугаар тушаалаар баримтын үнэ цэнийг нягтлан шалгах, байнгын хадгалалтанд баримт сонгох болон шилжүүлэхэд бэлтгэх ажлыг зохион байгуулах комиссыг 5 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй байгуулж албан бичигт тавих хяналтыг дээшлүүлснээр түгээмэл гардаг албан бичгийн боловсруулалт, утга найруулга, үгийн алдаа гаргах, хуулийн зүйл, заалтыг буруу хэрэглэх, бичих зэрэг зөрчил дутагдал таслан зогсоогдсон.

Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх Салбар комиссын дарга, Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны даргын 2019 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 8/1279 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Мэдээлэл, ажлын чиглэл”-ийн дагуу дараах ажил, арга хэмжээг зохион байгуулан үр дүнг тооцож, Цагдаагийн ерөнхий газрын Төв архивт хүргүүлсэн бөгөөд үзлэгийн урьдчилсан дүнгээр 21 аймаг дахь цагдаагийн газраас тус цагдаагийн газар 2-рт эрэмбэлэгдсэн.

Тус Цагдаагийн газрын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгтэй холбоотой Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга тэргүүтэй албаны хүмүүс 2019 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр тус цагдаагийн газрын үйл ажиллагаатай танилцсан.

11. Цагдаагийн газрын гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа, алба хаагчдын сахилга хариуцлагын өнөөгийн нөхцөл байдал, гэмт хэргийн шалтгаан нөхцөл, цаашид анхаарах асуудлыг тодорхойлох зорилгоор аймгийн иргэдээс 2019 оны 01 дүгээр сарын эхний 10 хоногт 9 асуулттай санал асуулгыг нийт 174 иргэнээс авч дүнг нэгтгэж үзэхэд санал асуулгад хамрагдсан 100 иргэн буюу 60.9 хувь нь Цагдаагийн байгууллагын ажил хангалттай сайн явагдаж байгаа, 44 иргэн буюу 25.2 хувь нь зарим үйл ажиллагаанд анхаарах шаардлагатай гэж санал асуулгад тэмдэглэсэн нь Цагдаагийн газрын үйл ажиллагаа иргэд, олон нийтэд жигд хүртээмжтэй хүрч байгааг харуулж байна.

1.2. Байгууллагын даргын зөвлөлийн хуралдаан тайлангийн хугацаанд хуралдсан байдал, шийдвэрлэсэн асуудлын талаар.

1. Цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөл нийт 19 удаа хуралдаж 129 асуудал хэлэлцэн шийдвэрлэсэн.

2. Стандартчилал Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2011 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Баримт бичгийн хэвлэмэл хуудас, тэдгээрт бүрдлүүдийг байрлуулахад тавих стандарт” болон Архивын Ерөнхий газрын даргын 2009 оны 69 дүгээр тушаалаар шинэчлэгдэн батлагдсан “Төрийн албан хэрэг хөтлөлтийн заавар”-ын дагуу Цагдаагийн газрын даргын хүний нөөц, алба хаагчдад холбоотой гаргасан Б тушаал 60, цагдаагийн газрын үйл ажиллагаатай холбоотой гаргасан А тушаал 65 нийт 125 тушаалыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу боловсруулан гаргасан.

1.3. Хүний нөөцийн бодлогын талаар:

1. Төрийн албаны тухай хууль, ЦЕГ-ын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан “Албан тушаал /ажлын байр/-ын тодорхойлолт боловсруулах /код 106/ журам”-ын дагуу тухайн албан тушаалын чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх албан хаагчид тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварын шаардлагыг шинээр баталгаажуулсан албан тушаалын тодорхойлолтуудыг алба хаагч бүртэй танилцуулсан.

2. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолын дагуу байгууллагын сул орон тоог нөхөх зорилгоор Цагдаагийн газрын даргын 2017 оны А/02 тушаалаар сонгон шалгаруулалт явуулах “Ажлын хэсэг”-ийг 5 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй байгуулсан ба холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтсийн 2019 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 56/1315 дугаартай ирүүлсэн “Ажлын чиглэл” дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан ба нийт 39 иргэн хамрагдаж, шалгуур шаардлагыг хангасан 8 иргэний материалыг Хүний нөөцийн хэлтэст 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 32/1067 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

3. Өнөөдрийн байдлаар хүний нөөцөд 8 иргэн бүртгэлтэй байна.

4. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Албан тушаал дэвшүүлэх /код-909/ журам”-д заасан болзол шалгуурыг хангасан 2 алба хаагчийг ахлагч бүрэлдэхүүнээс офицер бүрэлдэхүүнд шилжүүлж албан тушаал дэвшүүлэн томилуулсан.

5. Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийг суралцаж төгссөн 1 сонсогчийг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн Б/434 дугаар тушаалаар тус Цагдаагийн газрын Эрүүгийн цагдаагийн тасгийн эрүүгийн мөрдөгчөөр томилсон.

Цагдаагийн байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэдээс авсан шалгалтанд тэнцэж, цагдаагийн мэргэжлийн мэдлэг олгох дамжаанд суралцаж төгссөн 2 иргэнийг Цагдаагийн газрын даргын 2019 оны Б/07 тушаалаар томилж, цол олгосон.

6. Албаны ажлын шаардлагаар цагдаагийн газрын дотоодод ажлын байр өөрчилсөн 24 алба хаагч байгаа бөгөөд бусад цагдаагийн байгууллагаас шилжиж ирсэн 3, шилжсэн болон Цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон алба хаагч байхгүй, хүүхэд асрах чөлөө авсан 2 алба хаагч байна.

7. Цагдаагийн ерөнхий газрын дарга, Цагдаагийн газрын даргын тушаалаар нийт 14 алба хаагчдад цол, / цагдаагийн дэд хурандаа 1, цагдаагийн ахлах дэслэгч 4, дэслэгч 2, ахлагч 5, дэд ахлагч 2/ олгосон.

8. Цагдаагийн албаны тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 74 дүгээр тогтоолын дагуу Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар аймгийн төвөөс бусад суманд 5-аас дээш жил ажилласан 5 алба хаагчид 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшлыг олгосон.

9. Эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан 1 алба хаагч Төрийн одон медалиар шагнуулсан бөгөөд Цагдаагийн ерөнхий газрын шагналаар 30 алба хаагч шагнагдсан.

10. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан “Алба хаагчид албаны үнэмлэх, энгэрийн тэмдэг олгох, хураан авах журам /код 916/”-д заасны дагуу 8 алба хаагчын албаны үнэмлэх, энгэрийн тэмдгийг шинээр, 5 алба хаагчийг шинэчлэн олгуулсан.

11. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 38 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ алба хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын дагуу Цагдаагийн газрын нийт алба хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөөг Цагдаагийн газрын даргын 2019 оны 01 дүгээр тушаалаар баталсан Цагдаагийн газрын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндэслэж, тухайн алба хаагчийн албан тушаалын тодорхойлолтод уялдуулан гаргаж, батлуулсан бөгөөд Төрийн албаны тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь хэсэг, 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэг, Цагдаагийн албаны тухай хуулийн 72 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 38 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ алба хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэг, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/97 дугаар тушаалаар баталсан “Алба хаагчийн ажлыг үнэлэх /код-111/ журам”-

ын 111.4.5 дахь заалт, Цагдаагийн газрын даргын 2014 оны 09 дүгээр 02-ны өдрийн 131 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн газрын дотоод журам”-ын 3.6, 3.8, 4.4 дэх заалт, Цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн сар бүр дүгнэн, төлөвлөгөөний биелэлтийн явцын талаар ярилцлагыг хийж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

12. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дасан зохицох /код 944/ журам”-ын хэрэгжилтийг хангах, Цагдаагийн газарт сүүлийн 2 жилд томилогдсон 12 алба хаагчыг ажил албанд нь богино хугацаанд сургах, дасан зохицуулах, ажил мэргэжлийн алдаа дутагдал гаргуулахгүй байх, мэргэжлийн чиг баримжаатай болгох зорилгоор нэгдсэн уулзалт, ярилцлагыг 4 удаа зохион байгуулж, холбогдох хууль тогтоомж, журам, дүрэм болон Цагдаагийн албаны үнэт зүйл нь “Эх орон, ард иргэддээ өргөсөн тангараг”, Цагдаагийн албаны эрхэм зорилго “Найдвартай баталгаатай үйлчилгээ-иргэд, олон нийтийн итгэл, дэмжлэг”, Цагдаагийн албаны уриа “Амар амгалан амьдралын төлөө хамтдаа”, Цагдаагийн албаны бахархал нь “Түүхэн уламжлал, хуримтлуулсан туршлага, туг, бэлгэ тэмдэг, цагдаагийн албаны цол, үнэмлэх, энгэрийн тэмдэг, дүрэмт хувцас”-ны талаар халуун яриа өрнүүлсэн.

Шинээр томилогдсон алба хаагчдад Цагдаагийн газрын даргын тушаалаар сургагч багш томилон ажиллуулж хэвшсэн бөгөөд шинээр томилогдсон алба хаагчид хариуцсан ажилдаа богино хугацаанд дасан зохицож ажилдаа эзэн болоход шууд нөлөөлж байна.

1.4. Алба хаагчдын дунд зохион байгуулсан албаны сургалт, түүний үр дүнгийн талаар.

1. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/28 дугаар тушаалаар баталсан “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх 2019 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор Цагдаагийн газрын даргын 2019 оны А/14 дүгээр тушаалаар “Албаны сургалт явуулах баг байгуулж, сургалтын төлөвлөгөө, хуваарь”-ийг баталж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Албаны сургалтын “Сургалтын мэдээллийн нэгдсэн бүртгэлийн сан” програм хангамжийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой Цагдаагийн ерөнхий газрын Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтсийн даргаас 2019 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 5д/2073 дугаартай ирүүлсэн 5 төрлийн мэдээлэл, ажлын чиглэлийн дагуу тодорхой ажил, арга хэмжээг зохион байгуулж ажилласны үр дүнд сургалтын мэдээллийн сангийн үйл ажиллагаа хэвийн байдалд орж, сургалтын тоо мэдээ зөрүүтэй гарах, бүрэн шивж оруулахгүй орхигдуулах, давхардуулж оруулах, алба хаагчийн тоо, цагийг буруу шивж оруулах зэрэг зөрчил дутагдал арилсан болно.

2. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2019 онд дэвшүүлсэн зорилт түүний товч тайлбар, хэрэгжүүлэх шалгуур үзүүлэлтийг алба хаагч бүр өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөх, дадал зуршил болгон хэвшүүлэх зорилгоор Цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүнд 2019 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр сургалт зохион байгуулж, зорилтыг нэг загвараар хэвлэн алба хаагч нарт тараан хэрэгжилтийг хангуулсан.

Цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүний дунд зохион байгуулагдсан сахилга хариуцлагын зөвлөгөөн, хэлэлцүүлэг, уулзалтын нээлтэнд Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2019 онд дэвшүүлсэн зорилтыг байршуулан мөн цагдаагийн газрын хурлын танхимд байршуулсан зурагтаар өглөөний ярианы үед гаргаж алба хаагчдад сурталчлав.

3. Тайлангийн хугацаанд мэдвэл зохих хууль тогтоомжийн сургалтыг 5 удаа 17 цаг, алба хаагчийг хөгжүүлэх сургалтыг 7 удаа 15 цаг, дадлагажуулах сургалтыг 4 удаа 14 цаг, бие бялдарын бэлтгэлжилтийн сургалтыг 11 удаа 30 цаг, төрийн болон

төрийн бус байгууллагатай хамтран 8 удаа 15 цагийн сургалт нийт 41 удаагийн 101 цаг сургалт явуулж, давхардсан тоогоор 4557 алба хаагч хамрагдсан бөгөөд 14 сургалтын аудио, видео, бичлэг кино, 497 сургалтын материал, бодлого, аргачлал тус тус боловсруулж, Цагдаагийн газрын төсвөөс 243.000 төгрөгийг сургалтын зардалд зарцуулсан.

4. Цагдаагийн газрын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 79 дүгээр заалтанд “Цагдаагийн ерөнхий газар, алба, нэгж, ЦДЦСНТ болон бүсийн хэмжээнд зохион байгуулсан сургалтанд хамрагдсан алба хаагчид нийт бие бүрэлдэхүүнд сургалт зохион байгуулж хэвших” тухай тусгасан бөгөөд Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвөөс зохион байгуулсан сургалтанд хамрагдсан 22 алба хаагч давхардсан тоогоор цагдаагийн газрын 600 гаруй алба хаагчдад сургалт зохион байгуулсан бөгөөд алба хаагчдад сургалтын хүртээмжийг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой болж байна.

5. Цагдаагийн газрын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Хэсгийн төлөөлөгч нарын мэдлэг, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор сар бүр “Хэсгийн төлөөлөгч нарын нэгдсэн сургалт”-ыг зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар 7 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 90 алба хаагч хамрагдсан бөгөөд хэсгийн төлөөлөгч нарын мэдлэг, ур чадвар дээшлэх, дээд шатны байгууллага, эрх бүхий албан тушаалтны өгсөн даалгавар, үүрэг, ажлын чиглэл, зөвлөмж, мэдээллийн хэрэгжилт жигд хүрч хэрэгжилт хангагдах, тайлан мэдээ тогтоосон хугацаанд үнэн зөв бодитой гарах зэрэг олон талын ач холбогдолтой ажил болж байна.

Цагдаагийн газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 13-ны өдөр баталсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу сум хариуцсан эрүүгийн мөрдөгч нарын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, мэргэжил, чадварыг дээшлүүлэх, хамт олонч сэтгэхүй, нөхөрсөг харилцааг бэхжүүлж, харилцан туршлага солилцох зорилгоор 2019 оны 05 дугаар сарын 17, 18-ны өдрүүдэд Алтай сумын төвд хэсгийн төлөөлөгч нарын “Сум дундын бүс”-ийн сургалтыг зохион байгуулсан нь хэсгийн төлөөлөгч нарын мэдлэг, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх шинэлэг ажил болсон.

6. Цагдаагийн ерөнхий газрын Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвөөс 2019 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 24/173 дугаар албан бичгийн дагуу Цагдаагийн газрын 8 удирдах албан тушаалтан 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдөр “Удирдах ажилтанд зориулсан жендерийн цахим сургалт”-д хамрагдаж, тестийн шалгалтыг амжилттай өгсөн тул Жендерийн хорооноос “Ж1” сертификат олгов.

7. Аймгийн Прокурорын газартай хамтарсан сургалт-зөвлөгөөнийг 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр, 4 дүгээр сарын 25-ны өдөр, ажил хэргийн 12 уулзалтыг тус тус зохион байгуулсан бөгөөд эрүүгийн хууль, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, зөрчлийн тухай хууль болон зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудыг хэрэгжүүлэх явцад гарч буй хүндрэл бэрхшээл, түүнийг арилгах арга хэмжээний талаар хэлэлцэж, зөрчил дутагдлыг арилгуулах дээрх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж байна.

8. Цагдаагийн газрын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 75 дугаар заалтанд тусгагдсан “Холбогдох хууль тогтоомж, журам, дүрмийн талаарх сургалтыг нэгдсэн болон тасаг, хэсгүүд дотооддоо зохион байгуулах”, Цагдаагийн газрын даргын 2019 оны А/14 дүгээр тушаалаар батлагдсан “Албаны сургалт явуулах баг байгуулж, сургалтын төлөвлөгөө, хуваарь”-ийн хэрэгжилтийг хангах, алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, бие бялдрыг хөгжүүлэх, албан сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Цагдаагийн газрын алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүний 1 дүгээр улирлын нэгдсэн сургалтыг 2019 оны 04 дүгээр сарын 15, 16, 17-ны өдөр, 2 дугаар улирлын нэгдсэн сургалтыг 2019 оны 06 дугаар сарын 24-ний өдөр, 3 дугаар улирлын нэгдсэн сургалтыг 2019 оны 09 дүгээр сарын 19-ний

өдөр тус тус зохион байгуулсан бөгөөд нэгдсэн сургалтын хөтөлбөрийн дагуу нийт давхардсан тоогоор 40 сургагч багшийн 42 төрлийн сэдвийн хүрээнд удирдан зохион байгуулсан 30 цагийн танхим болон дадлагын сургалтанд давхардсан тоогоор 4400 гаруй алба хаагч хамрагдсан бөгөөд сургалтанд 12 төрлийн богино хэмжээний видео бичлэгийг ашиглав.

9. Алба хаагчдад “Даваа”, “Баасан” гарагийн өглөөний ярианы үед шинээр батлагдан гарсан болон нэмэлт, өөрчлөлт орсон хууль тогтоомж, бусад эрх зүйн акт, дээд шатны байгууллагаас ирүүлсэн мэдээ, мэдээллийг танилцуулан цагдаагийн газрын мэдээллийн самбарт, зарим хууль, тогтоомжийг файл хэлбэрээр цагдаагийн байгууллагын дотоод сүлжээнд байршуулж, алба хаагчдад бие даан судлах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

10. Албаны сургалтыг төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу зөвхөн онолын мэдлэг олгох бус практик ур, чадварыг онолтой хослуулах арга хэлбэрээр хэрэгжүүлж ажилласны үр дүнд сургалтын чанар, хүртээмж нь нэмэгдсэн, алба хаагчдын хууль хэрэглэх ур чадвар, харилцааны соёл, албаны бэлэн байдал, *цэрэжилч, жагсаалч байдал* дээшилж, алба хаагчдын зүгээс цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм, ёс зүйн дүрмийг нэг мөр ойлгож, мөрдөх хандлагад эерэг өөрчлөлтүүд гарч байна.

11. Алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор сургалтын нэгдсэн төв барих 10000 м² газрыг 15 жилийн хугацаатай тус аймгийн Сагсай сумын Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн А/42 дугаартай захирамжаар Цагдаагийн газарт эзэмшүүлсэн. Газрын гэрчилгээний дугаар 000000097.

12. Говь-Алтай аймаг дахь цагдаагийн газраас Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Баруун бүсийн цагдаагийн хүрээний байгууллагуудын 2019 онд хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах, алба хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх ажлын хүрээнд 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсан баруун бүсийн Цагдаагийн байгууллагуудын “Ахлах мөрдөгч нарын ажил мэргэжил, ур чадварын тэмцээн”-ийг зохион байгууллаа.

Тэмцээн хууль эрх зүйн мэдлэг, сэтгэн бодох чадвар, хэргийн газрын үзлэг, бие бялдар зэрэг 4 төрлөөр явагдсан бөгөөд тэмцээнд тус Цагдаагийн газраас Эрүүгийн цагдаагийн тасгийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч Н.Досжан, Хэрэг бүртгэх тасгийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч Б.Тунгышбай, Шуурхай удирдлагын тасгийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч Б.Хайырлыс нар оролцож, нийлбэр дүнгээр 73.1 оноогоор Хэрэг бүртгэх тасгийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч Б.Тунгышбай тэргүүн байр эзэлж цом, алтан медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар, 67.25 оноогоор Шуурхай удирдлагын тасгийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч Б.Хайырлыс гутгаар байр эзэлж, өндөр амжилт гаргав.

13. Цагдаагийн газрын 2019 оны гүйцэтгэлийн 94 заалт бүхий төлөвлөгөөг Цагдаагийн газрын даргын 2019 оны А/01 дүгээр тушаалаар баталсан бөгөөд төлөвлөгөөний 74 дүгээр заалтанд “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын талаарх сургалтыг тогтмол зохион байгуулах, Police code аппликейшнийг тогтмол ашиглах нөхцөл боломжоор хангах” тухай тусгагдсаны дагуу Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг алба хаагчдад судлуулах зорилгоор нэгдсэн 5 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 400 гаруй алба хаагчийг хамруулж, мөн энэ төрлийн сургалтыг цагдаагийн газрын тасаг, хэсгүүд дотооддоо тогтмол зохион байгуулж, Police code аппликейшнийг алба хаагчид үйл ажиллагаанд тогтмол ашиглах нөхцөл боломжоор хангах, үйл ажиллагаандаа хэрэглэж хэвшүүлэх талаар тогтмол мэдээ, мэдээлэл өгч ажилласны үр дүнд алба хаагчдын Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдлэг дээшилж, өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэглэж хэвшсэн бөгөөд ухаалаг гар утаснаас ямар ч үед хэрэглэх нөхцөл боломжийг бүрдүүлсэн.

14. Цагдаагийн ерөнхий газрын Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтсээс зохион байгуулж байгаа “Англи хэл-30 хором” аяныг хэрэгжүүлэх 12 заалт бүхий ажлын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Алба хаагчдаас англи хэлний мэдлэгтэй алба хаагчдын тувшинг тогтоосон судалгааг явуулсан бөгөөд 1 алба хаагч гүнзгий шатны, 1 алба хаагч дунд шатны, 10 алба хаагч анхан шатны, нийт 12 алба хаагч англи хэлний мэдлэгтэй байгаа бөгөөд гадаад хэлтэй алба хаагчдын судалгаа, бүртгэлийг шинэчилж мэдээллийн сан үүсгэв.

Тус Цагдаагийн газарт орчуулагч-цагдаагийн 2 орон тоонд англи, орос хэлний гүнзгий шатны мэдлэгтэй 2 алба хаагч ажиллаж байгаа нь аяныг үр дүнтэй, хүртээмжтэй зохион байгуулах нэг давуу тал гэж дүгнэж байна.

Цагдаагийн газрын сургалтын танхимд байрлуулсан зурагтаар өдөр бүр англи хэлний 5 үгийг гаргаж, нийт бие бүрэлдэхүүний өглөөний ярианы үед танилцуулан өдөр бүр 5 үг цээжлүүлсэн мөн цагдаагийн газрын төв байрны коридорт өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэглэгддэг англи хэлний ярианы орчуулгыг байршуулан алба хаагч бүрт 30-аас доошгүй хормыг хэл сурах, мэдлэгээ дээшлүүлэх, хөгжүүлэхэд зарцуулдаг байх хэвшлийг бий болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж байгаа бөгөөд 1 алба хаагч дунджаар 300 гаруй үгийг цээжлээд байна.

15. Цагдаагийн газрын ахлах албан тушаалтны манлайлал, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор 2019 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр цагдаагийн газрын ахлах ажилтнуудын дунд “Шилдэг ахлах ажилтан 2019” уралдааныг зохион байгуулсан бөгөөд уралдаанд бэлтгэх зорилгоор ахлах ажилтнууд мэдлэг, ур чадвараа дээшлүүлж, уралдаанд амжилттай оролцсон болно.

Уралдааны үед хууль, эрх зүйн, компьютерийн мэдлэг, бие бялдрын бэлтгэлжилт, тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх ур чадвар, мэдээллийн сангийн ашиглалт, шинэ санал санаачлага дэвшүүлсэн зэрэг нийт 10 төрлийн шалгалт авч дүнг нэгтгэв.

16. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2019 онд дэвшүүлсэн зорилтын хэрэгжилтийг хангах, цагдаагийн газрын ахлагч бүрэлдэхүүний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор удирдамжийн дагуу “Шилдэг ахлагч-2019” ур чадварын тэмцээнийг 2019 оны 04 дүгээр сарын 18-19 өдрүүдэд амжилттай зохион байгууллаа.

Тэмцээнд 51 ахлагч хамрагдсан ба үүний 48 эрэгтэй алба хаагч 2 эмэгтэй алба хаагч байсан ба удирдамжийн дагуу жагсаалын үзлэг, цэргийн хэргийн мэдлэг, ур чадвар, хууль, англи хэл, IQ-ийн бодлогоос бүрдсэн 50 асуулттай тест, замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг, жолоодлогын урч чадвар, 1000м, 100м-ийн гүйлт, гар дээр сунилт, туухай өргөлт, АКМ бууны задаргаа, угсаргаа, эссе бичлэг зэрэг нийт 9 төрлөөр ур чадвараа сорин өрсөлдсөн.

17. Хэсгийн төлөөлөгч нарын мэдлэг, ур чадварыг сайжруулах, ажлын үр дүнг дээшлүүлэх, албандаа хандах эерэг хандлагыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг нь олон нийтэд сурталчлах зорилгоор хэсгийн төлөөлөгч нарын дунд 2019 оны 09 дүгээр сарын 21, 22-ны өдрүүдэд “Шилдэг хэсгийн төлөөлөгч” шалгаруулах тэмцээн зохион байгууллаа.

Шилдэг хэсгийн төлөөлөгч шалгаруулах тэмцээний хүрээнд мэргэжлийн ур чадвар, хууль, эрх зүйн мэдлэг, гадаад хэлний мэдлэг, компьютерийн мэдлэг, албаны галт зэвсэг хэрэглэх ур чадвар, буудлага хийх, бие бялдрын бэлтгэлжилт, тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх ур чадвар, мал зүслэх, шүдлэх, им тамгыг нэрлэх, морь эмээллэх, унах ур чадвар, тээврийн хэрэгсэл жолоодох ур чадвар зэрэг нийт 16 төрлийн шалгалт авч дүнг нэгтгэв.

1.5. Алба хаагчдын нийгмийн асуудал, үүрэг гүйцэтгэх нөхцөл, боломжийг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний талаар.

1. Цагдаагийн газрын үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийг оновчтой, аргачлал, шалгуур үзүүлэлтийн дагуу тодорхойлж, үнэлгээ өгөх, урьдчилан сэргийлэх санал, зөвлөмж боловсруулан биелэлтэд хяналт тавих үүрэг бүхий эрсдэлийг удирдах орон тооны бус багийг Цагдаагийн газрын даргын 2018 оны А/65 дугаар тушаалаар байгуулсан бөгөөд баг Цагдаагийн газрын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг 4 чиглэлээр тодорхойлж, 2019 онд хариу арга хэмжээ авах 33 заалт бүхий ажлын төлөвлөгөөг 2019 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр баталж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Эрсдэл болон учирч болзошгүй, эсхүл учирч байсан хор уршигтай үр дагаврыг зөв тодорхойлж, урьдчилан сэргийлэх буюу бууруулах, хариу арга хэмжээ авах зорилгоор Цагдаагийн газрын тасаг, хэсгийн дарга, дотоодын цэргийн тусгай салааны захирагч, ахлах нягтлан бодогч нарт 2019 оны 01 дүгээр сарын 29-ны өдөр 17 заалт бүхий 02 дугаартай зөвлөмжийг хүргүүлэн хэрэгжилтийг хангуулав.

2. Алба хаагчдыг орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулах ажлын хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, ах ахуйн албанаас 2019 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн Захилга авах тухай 6/1427 дугаартай албан бичгийг нийт бие бүрэлдэхүүнд танилцуулж, цагдаагийн газрын 2 алба хаагчийг орон сууцтай болгох талаар Цагдаагийн ерөнхий газрын СААА-д холбогдох судалгааг хүргүүлж, шийдвэрлүүлээд байна.

Мөн 2 алба хаагч хөнгөлөлттэй зээлд хамрагдаж, орон нутагт баригдсан орон сууцанд хамрагдсан.

3. Алба хаагчдын үүрэг гүйцэтгэх нөхцөл боломжийг бүрдүүлэх, аюулгүй байдлыг хангах, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сум хариуцсан эрүүгийн мөрдөгч, нийтийн хэв журам хамгаалах, замын цагдаагийн чиглэлээр болон Цагдаагийн газрын угтах үйлчилгээнд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдад 38 ширхэг энгэрийн камерыг олгосон бөгөөд өдөр тутмын бичлэгийг хадгалж, мэдээллийн сан үүсгэж ажиллаж байна.

4. Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албанаас 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 6/437 дугаар албан тоотын дагуу цагдаагийн газрын 151 алба хаагч, ажилтан, 24 үл хөдлөх хөрөнгө, 19 тээврийн хэрэгслийг даатгалд хамруулах ажлыг зохион байгуулж, үүрэг гүйцэтгэх баталгааг хангаж ажиллав.

5. Цагдаагийн газрын тасаг, хэсгийн дарга нар давхардсан тоогоор 100 гаруй алба хаагчтай ганцаарчлан уулзаж, санаа бодлыг нь сонсож, 500 гаруй алба хаагчийн ахуй амьдралтай биечлэн танилцаж, зарим санал хүсэлтийг холбогдох дээд шатны байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх, түүнчлэн албандаа хүндэтгэлтэй хандах талаар нөхцөл байдлыг бодитой тайлбарлаж ойлгуулах талаар яриа таниулга хийх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан.

6. Цагдаагийн газрын дундын сангийн журмын дагуу нийт 32 алба хаагчдад 3.400.000 төгрөгний мөнгөн хэлбэрийн тусламж, дэмжлэг үзүүлэв.

7. Тайлангийн хугацаанд “Эрүүл-цагдаа” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, алба хаагч, ажилтны эрүүл мэндийг дэмжих, эрүүл зөв аж төрөх ёс, зан үйлийг хэвшүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл чийрэг бие бялдар, сэтгэл зүйг бэлтгэх ажлын хүрээнд давхардсан тоогоор 600 гаруй алба хаагчийг эрүүл мэндийн үнэ төлбөргүй үзлэг, сургалтанд хамруулах ажлыг 5 удаа зохион байгуулж, эрүүл мэндийг хамгаалав. Тухайлбал:

- "Хавдартай тэмцэх дэлхийн өдөр", “Элэгний хорт хавдраас урьдчилан сэргийлье” арга хэмжээний хүхээнд алба хаагч, ажилтнуудад элэгний хавдар үүсгэгч В, С вирус “гепатит” өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар мэдээ, мэдээлэл өгч, анхан шатны мэдлэг олгуулах 1 цагийн сургалтыг зохион байгуулан эрүүл мэндийн байгууллагаас гаргасан 180 ширхэг гарын авлага тараасан.

- Аймгийн Эрүүл мэндийн газраас алба хаагчдыг “Эхо” болон урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулсан бөгөөд нэгэн өндөр эрсдэлтэй

өвчин эмгэгтэй алба хаагч бүртгэгдээгүй ба тодорхой өвчний эмгэгтэй гарсан 3 алба хаагчийн судалгааг гаргаж, эмчлүүлсэн.

- “Эрүүл цагдаа хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлж, үр дүнг тооцож ажилласнаар алба хаагчдын дунд нийлтэг байдаг дотор эрхтэн, чих хамар хоолой, мэдрэлийн гаралтай өвчний гаралт буурсан гэж Нэгдсэн эмнэлгийн эмч нар дүгнэсэн болно.

- Алба хаагчдыг тарваган тахлаас урьдчилан сэргийлэх вакцинд хамруулах ажлыг 2019 оны 07 дугаар сард зохион байгуулж, тодорхой эрсдлээс урьдчилан сэргийлэв.

- Улсын гуравдугаар төв эмнэлэг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран “Хаан банк сан”-гийн санхүүжилтээр “Цусны даралт ихсэлтийн эсрэг аян”-ыг тус аймагт зохион байгуулсан бөгөөд алба хаагчдад цусны даралт ихсэх өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг үнэлэх үзлэг, оношлогоог үнэ төлбөргүй хийж, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.

8. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/37 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын ахмад, дунд, залуу үеийн залгамж холбоог хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд Цагдаагийн газарт ажиллаж байгаад цэргийн байнгын тэтгэвэрт гарсан ахмад ажилтнуудын мэдлэг, ажлын арга барил, туршлагыг өвлүүлэх, түгээн дэлгэрүүлэх, алба хаагчдын үйл ажиллагаанд уламжлуулах, ахмад, дунд, залуу, ирээдүй хойч үеийн холбоог бэхжүүлэх зорилгоор үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх багийг Цагдаагийн газрын даргын 2019 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар байгуулсан бөгөөд ахмад ажилтнуудтай нийт 6 удаагийн уулзалт, ярилцлагыг зохион байгуулаад байна.

9. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны А/82 дугаар тушаалаар баталсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Ахмадын байгууллага, ахмад настны талаар авах арга хэмжээ /код 947/ журам”, Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2018 оны “Ахмад настнуудын талаар авах зарим арга хэмжээний тухай” А/223 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулах зорилгоор “Сар шинэ”, “Наурыз”-ын баярыг угтан тус Цагдаагийн газрын 69 ахмад ажилтанд хүндэтгэл үзүүлэн гарын бэлэг гардуулж, “Ахмадын сан”-д 500.000 төгрөг хандивлав.

- ОХУ-ын Тыва улсад 2019 оны 06 дугаар сарын 14-6-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Тыва Улсын Дотоод явдлын яам, Дотоодын цэргийн ахмадын байгууллага байгуулагдсаны 20 жилийн ойн арга хэмжээнд цагдаагийн газраас дэмжлэг үзүүлэн 8 ахмад ажилтанг оролцуулав.

- Улаанбаатар хотод 2019 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр зохион байгуулагдсан “Монгол цэргийн нэгдсэн холбоо” төрийн бус байгууллагын анхдугаар их хуралд Захиргааны удирдлагын тасгийн дарга, Цагдаагийн газрын ахмадын зөвлөлийн нарийн бичгийн дарга Х.Бахыт нар оролцов.

- Увс аймагт 2019 оны 08 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулагдсан баруун 5 аймгийн ахмадуудын уулзалтанд цагдаагийн газрын ахмад ажилтнуудыг оролцуулсан.

- Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А/37 дугаар тушаалаар баталсан “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын ахмад, дунд, залуу үеийн залгамж холбоог хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах, хамтын ажиллагааг сайжруулах, ахмад ажилтнуудын санал хүсэлтийг сонсох, ажлын арга барил, туршлагыг нэвтрүүлэх, ахмад, дунд, залуу үеийн гурвалсан холбоог сайжруулж, хүндэтгэл үзүүлэх зорилгоор Олон улсын ахмадын өдрийг тохиолдуулан “Ахмад, дунд, залуу үеийн гурвалсан холбоог сайжруулах нь” уулзалт зохион байгуулах, ахмад ажилтнуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээний хөтөлбөрийг 2019 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр батлуулж, ажил, арга хэмжээг 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдөр зохион байгууллаа.

Хөтөлбөрийн дагуу алба хаагчид ахмад ажилтнуултай нэгдсэн болон салбар уулзалтуудыг зохион байгуулж, ахмад ажилтнуудад цагдаагийн газраас хэрэгжүүлж

байгаа ажил, арга хэмжээг танилцуулж, хамтын ажиллагааг сайжруулах талаар санал хүсэлтийг сонсож, гарын бэлэг гардуулан хүндэтгэлийг зоог барьж хүндэтгэл үзүүлэв.

10. Цагдаагийн газрын даргын өгсөн үүргийн дагуу нийт алба хаагчдын сэтгэл зүйн бэлтгэлжилтийн байдлыг үнэлэх зорилгоор 106 алба хаагчийг “Асуудлыг шийдвэрлэх байдал”, “Ачаалал даах чадвар”, “Стрессийн нөхцөлийг даах чадвар”, “Бие сэтгэцийн эрүүл мэндийг сахин хамгаалах байдал” зэрэг 4 төрлийн сэтгэл зүйн судалгаа, оношилгоонд хамруулан алба хаагч тус бүрээр тодорхойлов.

- “Стрессийн түвшинг” тодорхойлох судалгаанд 70 алба хаагчийг хамруулж, судалгааны үр дүнгээр стрессийн түвшин өндөр буюу дунд гарсан 10 алба хаагч тус бүрт нь 2 удаа ганцаарчлан уулзаж, стрессийн шалтгаан нөхцөлийг тодруулж, 3 алба хаагчид зан үйлдээ ажиллах аргачлал, даалгавар өгч, 10 алба хаагчид сэтгэл зүйн хямрал, стрессийн талаар бүлгээр ярилцлага хийж, 8 алба хаагчид 2 удаа “Ажлын байран дахь стресс”, “Ажлаас халшрах хам шинж”-ийн талаар мэдээлэл өгч, үр дүнг тооцож ажилласан.

- Цагдаагийн газрын тасаг, хэсгийн дарга нарын хүсэлтээр Эрүүгийн цагдаагийн тасгийн 21 алба хаагч, Мөрдөн байцаах тасгийн 7 алба хаагчийн сэтгэл зүйн бэлтгэлжилтийн дүгнэлтийг тус тус гаргаж тасгийн дарга нарт нь алба хаагчдын сэтгэл зүйн онцлогийг харгалзан харьцах талаар зөвлөмж хүргүүлж, үр дүнг тооцсон.

- Алба хаагчдын хууль, журмаар хүлээсэн үүргийн онцлогт тохирсон харилцааны соёлыг дээшлүүлэх ажлын хүрээнд иргэд, олон нийттэй шууд харилцдаг Замын цагдаагийн тасгийн алба хаагч нарт 2019 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр Цагдаагийн газрын дэд даргаар батлуулсан төлөвлөгөөний дагуу сэтгэцийн эрүүл мэнд, ажлаас халшрах хам шинжийн тухай ойлголт өгөх, стрессийг даван туулах арга барилд суралцах дадал эзэмшүүлэх зорилгоор аймгийн Нэгдсэн эмнэлгийн сэтгэцийн эмч нартай хамтран “Сэтгэцийн эрүүл мэндийн тухай ойлголт” сэдвээр 1 цаг, “Харилцах урлаг, сонсох чадвар” сэдвээр 1 цаг, “Ажлаас халшрах хам шинж, илрэх шинж” сэдвээр 1 цаг, нийт 3 цагийн сургалт зохион байгуулж, тайвшруулах аргад сургах 8 удаагийн дасгалд давхардсан тоогоор нийт 39 алба хаагчийг хамруулаад байна.

- Хэсгийн төлөөлөгч нарыг чадваржуулах зорилгоор “Хандлага ба дотоод мэдрэмж” сэдвийн 1 цагийн сургалтанд 13 алба хаагч, “Зан үйлийг өөрчлөх харилцаа” сэдвээр 2 цагийн сургалтанд 127 алба хаагчийг тус тус хамруулснаар алба хаагчид стрессийг давандуулах арга замд суралцаж, ажлын гүйцэтгэл сайжрахад шууд болон шууд бусаар нөлөөлж байна.

- Алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, өвчин эмгэг, хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх, бие бялдрын бэлтгэлжилтийг хангах, ажлын байранд хийх дасгал, хөдөлгөөний сайжруулах зорилгоор канторын 74 алба хаагчид “Ажлын байранд хийж болох энгийн 8 дасгал”, “Биеийн тамир спортоор хичээллэх нь таны сэтгэл санааг ямагт өөдрөг байлгана” сэдэвт санамж, зөвлөмжийг албаны өрөөнүүдэд байрлуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын 2019 оны “Соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө”-ний 3.11 дэх заалтыг хэрэгжүүлж, алба хаагчдад сэтгэцийн тулгамдсан асуудлын талаар мэдээлэл өгөх, стрессийг даван туулах арга замуудад суралцуулах зорилгоор 2019 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр “Стрессгүй өдөр” өдөрлөгийг зохион явууллаа.

Өдөрлөгийн хүрээнд алба хаагчдад стрессийг даван туулах арга замын талаар 1 цагийн сургалт зохион байгуулж, дасгал хөдөлгөөн хийлгэж, богино хэмжээний видео /шторк/ үзүүлж, алба хаагчид нэг нэгэндээ эелдэг найртай харьцаж, энэрэнгүй зөөлөн сэтгэл төрүүлж, инээмсэглэлээр нэг өдрийг өнгөрүүлсэн.

11. Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргаас 2019 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 3/120 дугаартай албан бичгээр ирүүлсэн Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд зохион байгуулах “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл

ахуйн аян-2019” арга хэмжээний дагуу нийт 20 төрлийн ажил, арга хэмжээг зохион байгуулж, биелэлт үр дүнг тооцож ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийн дагуу албан үүргээ гүйцэтгэж байхдаа гэмтэж, бэртсэн, осолд өртөж хохирсон, амь насаа алдсан цагдаагийн алба хаагчдыг судлан бүртгэх, дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус байнгын комиссыг Цагдаагийн газрын даргын 2019 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/19 дүгээр тушаалаар шинэчлэн байгуулсан.

Цагдаагийн газартай Хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа үйлчлэгч, сантехникийн слесарь, мужаан зэрэг энгийн 4 ажилчдад аймгийн Мэргэжлийн хяналтын газартай хамтран 2019 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 01 дугаартай 19 заалт бүхий аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгч, 2019 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 6 дугаартай 18 заалт бүхий хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар баталгааг авч, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Цагдаагийн газрын алба хаагч, ажилтан нарт Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай хууль”, “Хөдөлмөр, аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”, “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийн талаар аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч Т.Нурлан, Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч Б.Энхбаяр нар 1 цагийн сургалтыг зохион байгуулсан бөгөөд сургалтанд нийт 110 алба хаагч хамрагдаж, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын талаар мэдээ, мэдээлэлтэй болж өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх боломжтой боллоо.

Цагдаагийн газрын алба хаагчдаас албан үүргээ гүйцэтгэж байхдаа гэмтэж бэртсэн, осолд өртөж хохирсон, амь насаа алдсан алба хаагч бүртгэгдээгүй болно.

12. Алба хаагчдын албандаа хандах хандлага, илтгэл үнэмшил, албаараа бахархах болон бүтээлч сэтгэлгээ, байгууллагын соёлыг төлөвшүүлэх зорилгоор “Алдарын булан”-г шинээр барьж, ашиглалтад оруулсан нь байгууллагын соёлыг төлөвшүүлэх ажил нөлөө үзүүлж байна.

13. Цагдаагийн газрын иргэдийг хүлээж авах танхим, сургалтын танхим, бичиг хэргийн эрхлэгч, бичээчийн албан тасалгаа, Өлгий сумын төвд байрлах замын цагдаагийн хяналтын постонд тус тус засвар үйлчилгээ хийж, алба хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулав.

14. Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албанаас тус Цагдаагийн газарт нийт 35 ширхэг бэлэн бус торгуулийн машин, 35 ширхэг хэвлэгч, таблет 3 ширхэг, станц 7 ширхэг, тандагч багаж 3 ширхэг, драйгер 2 ширхгийг тус тус олгосон бөгөөд үйл ажиллагаандаа ашиглаж байна.

15. Хэсгийн төлөөлөгч, хэсгийн цагдаа нарын ажиллах амьдрах нөхцлийг сайжруулах ажилд сум орон нутгийн удирдлагын дэмжлэг, туслалцаа авах зорилгоор Цагдаагийн газрын дарга, сумын Засаг дарга, хэсгийн төлөөлөгч нарын хамтарсан “Гурвалсан гэрээ”-г 2019 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр байгуулан аймгийн Засаг даргаар баталгаажуулан биелэлтийг нь тооцон ажиллаж байна.

Өнөөдрийн байдлаар 1 тосгон, 12 сумын орон нутгийн хөрөнгөөс олон нийтийн цагдаагийн урамшил, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил, бензин шатах тослох материал болон бичиг хэргийн зардал, кобаны галчийн ажлын хөлс, урсгал засвар, түлш, энгэрийн камер, сумын төвийг камержуулах зэрэг ажил, арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар Алтай сумын Засаг даргаас БНХАУ үйлдвэрлэгдсэн Мустанг-5 маркийн мотоцикль, Юнителийн гэр интернет төхөөрөмж, Бугат сумын Засаг даргаас Тойота Приус-10 маркийн тээврийн хэрэгсэл, Юнителийн гэр интернет төхөөрөмж, Баяннуур, Булган сумдын Засаг даргаас Юнителийн гэр интернет төхөөрөмж, Улаанхус сум, Цагааннуур тосгоны Засаг даргаас бэлэн бус торгуулийн машины таблет төхөөрөмж, драйгер, Баяннуур сумын Засаг даргаас энгэрийн 2 ширхэг камер, драйгер, Алтанцөгц сумын Засаг даргаас драйгер зэрэг техник

хэрэгслийг тус тус шийдвэрлэсэн Цагдаагийн газрын хэвийн үйл ажиллагааг хангагдах, хуулиар хүлээсэн үүргээ зохих түвшинд гүйцэтгэхэд нөлөө үзүүлж байна.

16. Цагдаагийн газрын төв байрны гадна, дотор талын орчны нөхцөл байдал болон алба хаагчийн аюулгүй байдлыг хангах талаар байгууллагын дотор талд 45, гадна талд 5, нийт 50 тооны хяналтын камер байршуулан аюулгүй байдлыг хангасан.

Цагдаагийн газрын төв байрны аюулгүй байдлыг хангах зорилгоор галын утааны дохиоллын систем-2 ширхэг, дохиолол-1 ширхэг, агааржуулагч-3 ширхэг ширхэг, галын булан-3, ширхэг галын хор-42 ширхэг зэрэг багаж хэрэгслийг бололцооны хэрээр байршуулж хадгалалт, хамгаалалт, бэлэн байдлыг ханган ажиллаж байна.

17. Цагдаагийн газрын дундын сангийн хөрөнгөнөөс 100 төллөх хонь худалдан авч туслах аж ахуйн эхлэлийг тавьсан бөгөөд одоо нийт 230 гаруй хоньтой байна.

18. Цагдаагийн газрын төсвөөс хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, дотоодын цэргийн харуулын байр болон замын хөдөлгөөний хяналтын постын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор 9.900.000 төгрөгний өртөгтэй 80 орчим тоон нүүрсийг олгосон.

19. Тус цагдаагийн газрын харьяалалд цагдаагийн төв байр-..., 12 сум, 1 тосгоны цагдаагийн кобан-..., замын цагдаагийн хяналтын пост-..., цайны газар-..., нийт барилга байгууламж бүртгэлтэй байгаа бөгөөд барилга байгууламжийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт шаардлагыг хангаж байгаа эсэхэд дүгнэлт гаргуулах талаар аймгийн Мэргэжлийн хяналтын газарт 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 27/2131 дугаартай албан бичиг хүргүүлсэн.

- Албан бичгийн дагуу Мэргэжлийн хяналтын газрын Улсын байцаагчийн 2019 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 04-06-34/81 дугаартай дүгнэлтээр тус Цагдаагийн газрын харьяалалд байдаг Сагсай, Бугат, Толбо сум, Цагааннуур тосгоны цагдаагийн кобан болон замын цагдаагийн хяналтын пост, цайны газар, 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 04-06-034/99 дугаартай дүгнэлтээр үлдсэн Алтай, Буянт, Алтанцөгц, Баяннуур, Цэнгэл, Улаанхус, Дэлүүн, Ногооннуур, Булган сумын цагдаагийн кобаны барилга байгууламжууд барилга байгууламжийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт шаардлагыг хангаж байгаа талаар дүгнэлт гаргасан.

- Мэргэжлийн хяналтын газрын Улсын байцаагчийн 2016 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 04-06-034/443 дугаартай дүгнэлтээр “Цагдаагийн газрын төв байрны барилгын чанар, аюулгүй байдал нь барилгын холбогдох стандартыг, ажлын байрны нөхцөл нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, ажлын байрны орчин эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2000” стандартын шаардлагад нийцэж байгаа” тухай дүгнэлт гаргав.

Тус дүгнэлтийг дахин шалгах зорилгоор Мэргэжлийн хяналтын газрын Улсын байцаагч нар тус Цагдаагийн газарт ажилласан бөгөөд MNS 4990:2000 стандартыг шаардлагад нийцэж байгаа тул 04-06-034/443 дугаартай дүгнэлтийг өөрчлөх шаардлагагүй гэж үзэв.

- Бүх сумын цагдаагийн кобанд Галын түймрийн улсын хяналтын байцаагч 2018 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 0016564, 0016573-852 дугаартай ажлын байрны галын аюулгүй байдлыг хангасан тухай дүгнэлт гаргасан бөгөөд дүгнэлт 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдөр хүртэл хүчинтэй болно.

- Аймгийн Онцгой байдлын газарт Цагдаагийн газрын архивын өрөөний ажлын байрны галын аюулгүй байдлын талаарх дүгнэлт гаргуулах тухай 2019 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 32/2025 дугаартай албан бичиг хүргүүлсний дагуу аймгийн Онцгой байдлын газрын Галын түймрийн улсын хяналтын байцаагч Цагдаагийн газрын архивын өрөөнд 2019 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 01907531 дугаартай ажлын байрны галын аюулгүй байдлыг хангасан тухай дүгнэлт гаргасан.

20. Тус Цагдаагийн газраас алба хаагчдын гүйцэтгэж буй албан үүрэгтэй нь холбогдуулан алба хаагчдад өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангаж

ажиллах талаар 22 төрлийн зааварчилга өгч, 10 төрлийн баталгаа авч хэрэгжилтийг хангуулав.

21. Сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын ажиллах, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор 5 сумын цагдаагийн кобанд урсгал засвар хийж, 4 кобаныг камержуулсан.

22. Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтсийн даргын 2019 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 3б/3662 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Цагдаагийн алба хаагчдын эрх ашгийг хамгаалах холбоо” төрийн бус байгууллагатай алба хаагчдын эрх, ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх, эрх зүйн туслалцаа, зөвлөгөө өгөх чиглэлээр хамтран ажиллах, тус холбооны үйл ажиллагааг танилцуулах чиглэлээр 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсан цахим, уулзалт, ярилцлагад цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүнийг хамруулав.

23. Эргүүл, жижүүр, харуулын үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын агсамжийн хэрэгжилтэнд өдөр тутас хяналт тавьж, өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэглэж хэвшүүлсэн.

24. Цагдаагийн газрын мэдүүлэг авах өрөөнүүдийн тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангаж, дуу-дүрсний бичлэгийг засварлах, устгах, эрсдэлээс хамгаалах, нууцлал, аюулгүй ажиллагааг бүрэн хангаж ажиллах эрх бүхий албан тушаалтнуудыг Цагдаагийн газрын даргын 2019 оны 04 дүгээр сарын 09-ны өдрийн А/31 дүгээр тушаалаар томилж, тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Цагдаагийн газрын мэдүүлэг авах өрөөнүүдийн тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангаж, дуу-дүрсний бичлэгийг засварлах, устгах, эрсдэлээс хамгаалж ажиллахыг Холбоо, мэдээллийн инженерт үүрэг болгосон.

25. Тус цагдаагийн газрын техник хэрэгслийн хангамжийг сайжруулах зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албанаас ЗИЛ-131 маркийн тээврийн хэрэгсэл олгосон бөгөөд үйл ажиллагаандаа ашиглаж байна.

26. Алба хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор нэг үйлдэлтэй 5 ширхэг хэвлэх машиныг худалдан авч, алба хаагчдад олгосон.

1.6. Нутаг дэвсгэрийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргаар уламжлан шийдвэрлүүлсэн ажил, арга хэмжээ, төсөв хөрөнгө, зарцуулалт, үр дүнгийн талаар.

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 8 дугаар хуралдааны 51 дүгээр тогтоол, 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 9 дүгээр хуралдааны 66 дугаар тогтоолоор орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр тус Цагдаагийн газарт хамгаалалтын хайс хашаа хийлгэхэд шаардагдах 10.000.000 төгрөг, цагдаагийн газрын хашаанд 5.000.000 төгрөг, бэлэн бус торгуулийн машин худалдаж авахад шаардагдах 6.800.000 төгрөг, нийт 21.800.000 төгрөгний санхүүжилтийг шийдвэрлэсэн бөгөөд аймгийн Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/148 дугаар захирамжаар хашаа, тоног төхөөрөмжийг нийлүүлэх ажлын худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулах, хэрэгжүүлэх эрхийг Цагдаагийн газарт шилжүүлсэн.

- Хайс хашааг Цагдаагийн газрын даргын тушаалаар байгуулсан ажлын хэсэг хүлээн авч үйл ажиллагаанд ашигласнаар хэв журмын хамгаалалтыг зөрчил дутагдалгүй зохион байгуулахал ач холбогдолтой болж байна.

- Мөн бэлэн бус торгуулийн машин худалдаж авах ажлын хүрээнд тоног төхөөрөмжийг нийлүүлэх аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан нийт бэлэн бус 4 машин, тандагч 1 багаж нийлүүлэв.

2. Долоо хоног бүрийн “Баасан” гарагт зохион байгуулагддаг аймгийн удирдах албан тушаалтны шуурхай зөвлөгөөнд нийт удаа оролцож, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, хамтын ажиллагааны талаар нийт 17 удаа тодорхой мэдээ, мэдээлэл өгч, шуурхай зөвлөгөөнд оролцсон

нийт 40 гаруй төрийн байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажилласан.

1.7. Цагдаагийн байгууллагын чиг үүрэгтэй холбоотой бусад төрийн болон төрийн бус байгууллагаас хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрт хамрагдаж байгаа болон бие даан хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, хугацаа, үр дүнгийн талаар.

1. Тус аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 9 дүгээр хуралдааны 60 дугаар тогтоолоор архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, согтуугаар үйлдэгддэг гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг буруулах, иргэд, олон нийтийн оролцоог хангах замаар архидан согтуурахтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор “Эрүүл зан үйлийг дэмжсэн архидалтгүй аймаг-Баян-Өлгий” 1 жилийн хугацаатай дэд хөтөлбөр, мөн 62 дугаар тогтоолоор хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, буруулах, жолооч нарын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, замын хөдөлгөөний соёлыг дээшлүүлэх зорилгоор “Соёлтой жолооч” 1 жилийн хугацаатай дэд хөтөлбөрийг тус тус батлуулж, төлөвлөгөөний дагуу тодорхой цогц ажил, арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.

Дээрх дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил иргэд, олон нийтийн оролцоо хангагдан хандлага, сэтгэлгээ өөрчлөгдөж, хэрэг, зөрчил буурах эерэг өөрчлөлтүүд гарах юм.

Тухайлбал:

Хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгөөнд 11.000 гаруй иргэнд ухуулга, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, 1000 гаруй иргэнийг сургалтанд хамруулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр 80 гаруй удаа мэдээ, мэдээлэл бэлтгэн түгээж, 12 төрлийн 3000 гаруй гарын авлага, санамж, зөвлөмж тарааж, нэгдсэн байдлаар 15 удаа хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, 3 удаа өдөрлөг зохион байгуулаад байна.

2019 оны мөн үеийн байдлаар архины албадан эмчилгээнд нэн тэргүүнд хамруулах 14 хүнийг архинд донтох өвчтэй эсэхийг эрүүл мэндийн байгууллагаар дүгнэлт гаргуулан, үүнээс 1 хүнийг албадан эмчилгээнд хамруулах тухай сум дундын шүүхийн 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 130/ШШ2019/00195 дугаартай шийдвэрийг гаргуулж, эмчилгээнд хүргүүлээд байна.

Мөн 2019 оны 05 дугаар сарын 24-ний өдөр архинд донтох өвчтэй 4 хүнийг албадан эмчилгээ хийлгэх шийдвэрийг гаргуулахаар шүүхэд материалыг хүргүүлсэн.

Тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан “Согтуурах, мансуурах донтой нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын дүгнэлтээр тогтоогдсоны дараа тухайн хүн өөрөө сайн дурын үндсэн дээр энэ төрлийн эмчилгээнд хамрагдах хүсэлтээ цагдаагийн байгууллагад бичгээр гаргасан тохиолдолд хувийн байдлыг нь харгалзан албадан эмчилгээнд явуулахгүй байж болно” 6.3-д заасан “Энэ хуулийн 6.1-д заасны дагуу хүсэлт гаргасан өдрөөс хойш нэг сарын хугацаанд эмчилгээнд хамрагдаагүй тохиолдолд энэ хуулийн 4.2-т заасны дагуу цагдаагийн байгууллага тухайн хүнийг албадан эмчилгээнд явуулах саналыг шүүхэд гаргана” гэсэн заалтын дагуу 9 хүн сайн дурын эмчилгээнд хамрагдах хүсэлтийг цагдаагийн байгууллагад өгч, сайн дурын эмчилгээнд хамрагдаад байна.

Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль тогтоомж, архины хор хөнөөлийн талаарх 23 удаагийн 25 цагийн цуврал сургалт, яриа таниулгыг ерөнхий боловсролын сургууль, төрийн болон төрийн бус байгууллагуудад зохион байгуулсан.

1.8. Тайлангийн хугацаанд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ.

1. Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргаас 2019 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хяналт тавих, нэгтгэх ажил хариуцсан албан тушаалтнуудыг томилсонтой холбогдуулан 3/04 дугаартай албан бичгээр ирүүлсэн албан даалгаврыг хэрэгжүүлэх 14 заалт бүхий ажлын төлөвлөгөөг 2019 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр баталж, хэрэгжилтийг 100 хувь ханган 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 32/711 дүгээр албан бичгээр алба хаагчдын ХАСХОМ-ын тайлан, маягт болон албан даалгаврын хэрэгжилтийг тус тус хүргүүлсэн.

2. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний нэг дэх үе шатны төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргын 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 3/77, 2019 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 3/86, 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 3/102 дугаартай ирүүлсэн үүрэг, ажлын чиглэлийн хэрэгжилтийг хангах 14 заалт бүхий ажлын төлөвлөгөөг 2019 оны 03 дугаар сарын 12-ний өдөр баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Авлигаас урьдчилан сэргийлэх цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа /код-139/ журам”-ын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Цагдаагийн газрын тасаг, хэсгийн дарга нарт 2019 оны 03 дугаар сарын 13-ны өдөр 5 заалт бүхий 03 дугаартай зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтийг хангуулав.

3. Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг мэдүүлэх үүрэг бүхий 67 албан тушаалтны 2018 оны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг, шинээр, шилжин болон дэвшин томилогдохоор нэр дэвшсэн 2 алба хаагчийн материалыг Цагдаагийн ерөнхий газарт тус тус хүргүүлж, нэр дэвшсэн этгээдээс албан тушаалд томилогдсон 2 алба хаагчийн тушаал, шийдвэрийг мэдээллийн цахим бүрдүүлэлтийн санд бүртгэсэн.

4. Алба хаагчдад иргэдээс авлига өгөхийг санал болгосон болон авлига өгөхөөр завдсан тохиолдолд холбогдох албан тушаалтан, байгууллагад заавал мэдээлдэг байх, мэдээлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар “Авлигын эсрэг хууль”, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулиудын холбогдох заалтуудаар зохион байгуулсан 3 удаагийн, 3 цагийн сургалтанд 300 гаруй алба хаагч хамрагдав.

5. Авлигын эсрэг хууль, хөтөлбөрийг сурталчлах чиглэлээр иргэдийг хүлээж авах танхимд тусгайлан булан, самбар гарган үйл ажиллагаанд ашиглаж байна.

6. “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг”, Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг”-ийг тус тус бүртгэх, хадгалах, хяналт тавих, нэгтгэх ажил хариуцан ажиллаж буй алба хаагчдын сарын үндсэн цалингийн 25 /хорин тав/ хувиар тооцож олгох талаар Цагдаагийн газрын даргын 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн Б/05 дугаар тушаал гаргаж, хэрэгжилтийг хангуулан ажилласан.

7. Мөн алба хаагч бүрээс авлигаас ангид байхаар талаар 2019 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 5 заалт бүхий 07 дугаартай баталгаа гаргуулан авсан бөгөөд өнөөдрийн байдлаар цагдаагийн газрын алба хаагчдаас албан тушаал, эрх мэдлээ хувийн ашиг сонирхолдоо ашигласан зөрчил бүртгэгдээгүй.

8. Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтсээс 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулсан “Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын алба хаагчдын ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, удирдах болон эрх бүхий албан тушаалтнуудыг чадавхжуулах” цахим сургалтанд Цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөлийн гишүүд оролцсон бөгөөд “ХАСХОМ, ХАСУМ, ашиг сонирхлын зөрчил, анхаарах асуудал”, “Авлигаас урьдчилан сэргийлэх арга зам”, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, Цагдаагийн

байгууллагын явц байдал цаашид анхаарах асуудал”, “Авлигын шалтгаан хор хөнөөл”-ийн талаарх мэдлэгээ дээшлүүлэв.

9. Цагдаагийн газрын төв байрны урьд орчин үеийн шаардлага хангасан 3.30*1.50 метрийн, Цагдаагийн газрын иргэдийг хүлээж авах танхимд 110*80 см хэмжээтэй самбарыг шинээр хийж, байрлуулсан авлигаас урьдчилан сэргийлэх холбогдох хууль тогтоомж, журам, дүрэм, төлөвлөгөө, гүйцэтгэл, санамж, зөвлөж, мэдээ, мэдээллийг байршуулан сурталчилж, үйл ажиллагаанд ашигласнаар авлигыг үл тэвчих ёс суртахууны зохистой хандлагыг төлөвшүүлэхэд нөлөө үзүүлж байна.

Иргэдийг хүлээж авах танхимд байрлуулсан телевизээр холбогдох хууль тогтоомжийг сурталчилсан, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлийн богино хэмжээний видео /шторк/ бичлэгийг гарган цагдаагийн газраас үйлчилгээ авахаар ирсэн иргэдэд сурталчилж байна.

Авлигын эсрэг хууль, хөтөлбөрийг сурталчлах ажлын хүрээнд Цагдаагийн газрын иргэдийг хүлээж авах танхимд тусгайлан булан гарган үйл ажиллагаанд ашигласнаар авлигаас урьдчилан сэргийлэх холбогдох хууль тогтоомж, журам, дүрмийг сурталчлах ажил үр дүнтэй хэрэгжиж байна.

10. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/109 дугаартай тушаалын дагуу Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтсээс 2019 оны 05 дугаар сарын 09-10-ны өдрүүдэд Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтанд Хүний нөөцийн мэргэжилтнийг хамруулсан бөгөөд сургалтын талаар нийт бие бүрэлдэхүүнд 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдөр 1 цагийн сургалтыг зохион байгуулсан болно.

11. Монгол Улсын Авлигатай тэмцэх газрын дарга, Цагдаагийн ерөнхий газрын даргын хамтран баталсан “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын сахилга, ёс зүй, аюулгүй байдлыг сайжруулах, авлигын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах итгэлийн уралдааны удирдамж”-ийн дагуу Авлигын эсрэг хууль тогтоомж, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2019 онд дэвшүүлсэн зорилт, цагдаа, дотоодын цэргийн алба хаагчийн сахилгын болон ёс зүйн дүрэм, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг алба хаагчдад сурталчлан таниулах, тэдний бүтээлч ажиллагааг дэмжин урамшуулах замаар авлигын гэмт хэрэг, авлига, ашиг сонирхлын болон сахилга, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эерэг хандлага, ёс суртахуун төлөвшүүлэх зорилгоор алба хаагчдын дунд итгэлийн уралдааныг Цагдаагийн газрын сургалтын танхимд 2019 оны 05 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулсан.

Итгэлийн уралдаанд 5 алба хаагч оролцсон бөгөөд шалгарсан итгэл болон илтгэгчийн зохион байгуулсан ажил, арга хэмжээний тайланг Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтэст 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 27/2602 дугаартай албан бичгээр хүргүүлэв.

12. Цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүний нэгдсэн сургалтыг 2019 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулах үеэр алба хаагчдад “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулиудын холбогдох заалт, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар 1 удаагийн, 2 цагийн сургалтыг зохион байгуулав.

Алба хаагчдад авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлийн богино хэмжээний видео /шторк/ бичлэгийг гарган алба хаагчдад сурталчилсан.

- Цагдаагийн газрын төв байрны урьд 2.32*3.0 метрийн хэмжээтэй 30.000.000 төгрөгөний өртөгтэй “LED” дэлгэцийг байрлуулж, түүгээр дамжуулан авлигын хор уршгийн талаарх мэдээ, мэдээлэл, санамж, зөвлөмжийг түгээж байна.

1.9. Алба хаагчдын үйл ажиллагаатай холбоотой иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт, тэдгээрийн шийдвэрлэлтийн талаар.

1. Цагдаагийн газрын удирдлагад иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас 17 алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 14 өргөдөл, гомдол ирүүлсэн бөгөөд бүртгэлд оруулан дугаар олгож, албаны шалгалт явуулж, хуулийн хугацаанд өргөдөл, гомдол гаргагчид хариуг нь шуурхай хүргүүлснээр цагдаагийн байгууллага, иргэдийн итгэлцэл сайжрахад нөлөө үзүүлсэн гэж дүгнээд байна.

Өөрөөр хэлбэл Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаар иргэдийн дунд эерэг ойлголт бий болсон.

Өргөдөл, гомдолд 17 алба хаагчийг холбогдуулан шалгасны 11 буюу 64.7 хувийг офицер, 6 буюу 35.2 хувийг ахлагч бүрэлдэхүүн эзэлж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 6 нэгж буюу 35.2 хувиар өссөн байна.

Төрлөөр нь авч үзвэл: 10 буюу 71.4 хувийг хууль ёс, хүний эрх чөлөөг зөрчсөн, 3 буюу 21.4 хувийг бусдыг чирэгдүүлж танил тал харсан, 1 буюу 7.1 хувийг ажлын хариуцлага алдсан гэх зөрчлүүд тус тус эзэлж байна.

Өргөдөл, гомдлыг бүртгэж албаны шалгалт явуулахад 13 алба хаагчид холбогдох зөрчил нотлогдоогүй ба 4 алба хаагчид сахилгын шийтгэл оногдуулав.

2. Монгол Улсын Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах төв” 11-11-д тус цагдаагийн газрын үйл ажиллагаа, алба хаагчдад холбоотой иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ямар нэгэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт, бүртгэгдээгүй болно.

Харин Цагдаагийн ерөнхий газрын алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хүлээн авах 126 дугаар утсанд цагдаагийн алба хаагч хэл амаарх доромжилсон гэх 1 гомдол мэдээлэл бүртгэгдсэн бөгөөд албаны шалгалт явуулахад тухайн алба хаагч сахилга, ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдоогүй болно.

3. Цагдаагийн газрын удирдлагад хандаж иргэд, алба хаагчдаас 88 өргөдөл, гомдол, мэдээлэл ирүүлсэн бөгөөд “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль”, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн Б/99 дүгээр тушаалаар баталсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Өргөдөл, гомдол хүлээн авч шийдвэрлэх /код 121/ журам”-ын дагуу хүлээн авч бүртгэн, хуулийн хугацаанд шийдвэрлэж хариу хүргүүлсэн.

Төрлөөр нь авч үзвэл: 46 буюу 52.2 хувийг ажилд орох, суралцахыг хүссэн, 3 буюу 3.4 хувийг ажилд дахин орохыг хүссэн, 10 буюу 11.3 хувийг чөлөө хүссэн, 14 буюу 15.9 хувийг ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 7 буюу 7.9 хувийг тэтгэвэр тэтгэмж, орон сууц хүсэн, 2 буюу 2.3 хувийг бусад төрлийн өргөдөл, гомдол эзэлж байна.

1.10. Алба хаагчдын сахилга, хариуцлага, ёс зүйн чиглэлээр зохион байгуулсан ажил арга хэмжээний талаар.

1. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Сахилга хариуцлага, дэг журмыг сайжруулах тухай” 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжилтийг хангах зорилгоор 31 заалт бүхий ажлын төлөвлөгөөг, Засгийн газрын 2018 оны “Төрийн албаны сахилга хариуцлага дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор 26 заалт бүхий ажлын төлөвлөгөөг 2019 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр тус тус баталж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

2. Цагдаагийн газрын алба хаагчдаас 16 алба хаагч сахилга, ёс зүйн зөрчил гаргасан үүнийг өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад мөн үеийн түвшинд байна.

Сахилга, ёс зүйн зөрчил гаргасан алба хаагчдын 10 буюу 62.5 хувийг офицер, 6 буюу 37.5 хувийг ахлагч бүрэлдэхүүн эзэлж байна.

Хэлбэрийн хувьд авч үзвэл:

1. Ажлын хариуцлага алдсан 3 буюу 18.7,
2. Архидан согтуурсан 5 буюу 31.2,
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль зөрчсөн 4 буюу 25,
4. Үүрэг, даалгавар үл биелүүлсэн 1 буюу 6.2,
5. Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм зөрчсөн 2 буюу 12.5,
6. Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм зөрчсөн 1 буюу 7.1 хувийг тус тус эзэлж байна.

Сахилга, ёс зүйн зөрчил гаргасан алба хаагчдад оногдуулсан сахилгын шийтгэлийн төрөл:

1. Сануулах 5 буюу 31.2 хувь,
2. Сарын үндсэн цалингийн хэмжээг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах 5 буюу 31.2 хувь,
3. Цагдаагийн цол бууруулах 3 буюу 18.7 хувь,
4. Цагдаагийн албанд 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах 2 буюу 12.5 хувь,
5. Албанаас халах 1 буюу 6.2 хувийг тус тус эзэлж байна.

Тайлангийн хугацаанд сахилга, ёс зүйн зөрчлийн 8 буюу 50 хувийг дотоод хяналтаар, 8 буюу 50 хувийг гадны хяналтаар илрүүлсэн нь дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 5 зөрчил буюу 62.5 хувиар өссөн байна.

2018 оны эхний 9 сарын байдлаар тус Цагдаагийн газрын 2 тасгийн даргад Дээд шатны байгууллагаас сахилгын шийтгэл оногдуулж байсан бол энэ оны эхний 9 сарын байдлаар Цагдаагийн газрын тасаг, хэсгийн дарга нараас сахилгын шийтгэл хүлээсэн алба хаагч байхгүй.

3. Цагдаагийн ерөнхий газрын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.1.4 дэх заалт, Цагдаагийн газрын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 7, 8, 9 дүгээр заалтын хэрэгжилтийг хангах, алба хаагчдын сахилга, хариуцлагын байдалд дүн шинжилгээ хийж, цаашид анхаарах асуудлаа тодорхойлох зорилгоор Цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүний 2019 оны 01 дүгээр улирлын “Сахилга хариуцлагын зөвлөгөөн”-ийг 2019 оны 03 дугаар сарын 30-ны өдөр, 2019 оны 03 дугаар улирлын улирлын “Сахилга хариуцлагын зөвлөгөөн”-ийг 2019 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр тус тус зохион байгуулсан.

Мөн энэ оны 02 дугаар улирлын “Сахилга хариуцлагын зөвлөгөөн”-ийг үр дүнтэй, чанартай, хүртээмжтэй зохион байгуулах зорилгоор ахлагч бүрэлдэхүүний дунд 2019 оны 05 дугаар сарын 24-ний өдөр, офицер бүрэлдэхүүний дунд 2019 оны 06 дугаар сарын 24-ний өдөр тус тус зохион байгуулсан нь шинэлэг арга хэлбэрийг нэвтрүүлэх, сахилга хариуцлагын зөвлөгөөний үр дүнг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой боллоо.

Цагдаагийн газрын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 8 дугаар заалтын дагуу Цагдаагийн газрын тасаг, хэсгүүд “Сахилга хариуцлагын зөвлөгөөн”-ийг сар бүр зохион байгуулсан ба давхардсан тоогоор 900 гаруй алба хаагч хамрагдав.

Сахилгын зөрчлийн шалтгаан нөхцөлийг судалж, дүн шинжилгээ хийж үзэхэд хувь хүний буруутай үйл ажиллагаа, ёс зүй хангалттай төлөвшөөгүй зэрэг гол шалтгаан нөхцөл тогтоогдоод байна.

Цагдаагийн газрын 2019 оны 03 дугаар улирлын сахилгын зөвлөгөөний үеэр Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2019 онд дэвшүүлсэн зорилт, зорилтыг хэрэгжүүлэх шалгуур үзүүлэлтийг хангах, сахилга, ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгуулах талаар нийт бие бүрэлдэхүүнд 33 дугаартай 27 заалт бүхий үүрэг, ажлын чиглэл өгч, биелэлт, үр дүнг энэ оны 4 дүгээр улирлын сахилгын зөвлөгөөний үеэр тооцохоор шийдвэрлэв.

“Сахилга хариуцлагын зөвлөгөөн”-ийг үр дүнтэй, чанартай, хүртээмжтэй зохион байгуулах зорилгоор офицер бүрэлдэхүүний дунд 2019 оны 06 дугаар сарын 24-ний өдөр сахилга хариуцлагын зөвлөгөөний зохион байгуулсан бөгөөд

зөвлөгөөний үед алба хаагчдаас гаргасан санал, Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм, сахилгын дүрмийг хэрэгжилтийг хангах зорилгоор зөвлөж, санамж гарган цагдаагийн газрын хурлын танхимын алба хаагчдын ширээнд байршуулсанаар дүрмийг нэг мөр хэрэгжүүлэх, дүрмийг мэдээгүйгээс шалтгаалан гардаг сахилга, ёс зүйн зөрчил буурахад ач холбогдолтой боллоо.

- Сахилгын зөвлөгөөний үед алба хаагчдаас цагдаагийн газрын тасаг, хэсгийн дарга нарын манлайлал ямар түвшинд байгаа талаарх санал асуулга авч дүнг нэгтгэж үзэхэд санал асуулганд хамрагдсан алба хаагчдын 27 буюу 40 хувь нь сайн гэсэн сонголтыг дугуйлсан байна.

- Мөн цагдаагийн газрын алба хаагчдаас энэ оны 04 дүгээр улирлыг “Сахилгын зөрчилгүй улирал” болгох уриалга гаргаж хэрэгжүүлэхээр тогтов.

4. Цагдаагийн газрын алба хаагчдын 2018 оны сахилга, ёс зүйн байдал, сахилгын зөрчил гарч байгаа шалтгаан нөхцөл, түүнийг арилгуулах арга зам, цаашид авах арга хэмжээний талаар болон сахилгын шийтгэлийн хор уршигийн талаар танилцуулга бэлтгэн алба хаагч нарт танилцуулах, хэлэлцүүлэг зохион байгуулах, сахилгын арга хэмжээ авагдсан алба хаагч нар хамт олны өмнө амлалт өгөх, сахилгын зөвлөгөөн гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, дараагийн зөвлөгөөнд танилцуулах зэрэг шинэлэг хэлбэрээр зохион байгуулж хэвшсэн.

5. Цагдаагийн газрын Сахилга, ёс зүйн хорооноос алба хаагчдаас гаргасан сахилга, ёс зүйн зөрчил, хариуцлагын байдалд дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоож, арилгуулах, сахилга хариуцлагыг дээшлүүлэх талаар тасаг, хэсгийн дарга, дотоодын цэргийн тусгай салааны захирагч нарт 2019 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 12 заалт бүхий 01 дугаартай хэрэгжих боломжтой зөвлөмжийг хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

6. Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргаас 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 3/73 дугаар албан бичгээр “Итгэлцлийн гэрээ” байгуулахтай холбоотой ирүүлсэн үүргийн дагуу Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/57 дугаар тушаалаар баталсан “Итгэлцлийн гэрээ”-ний загварын дагуу Цагдаагийн газрын нийт 151 алба хаагч, ажилтан бүртэй 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдөр байгуулан хэрэгжилтийг хангуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж байна.

Цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүнд гэрээний нийтлэг үндэслэл, талуудын хүлээсэн 7 төрлийн эрх, үүрэг, удирдах албан тушаалтны хүлээсэн 15 төрлийн үүрэг, алба хаагч, ажилтны хүлээсэн 5 төрлийн эрх, алба хаагч, ажилтны хүлээсэн 6 төрлийн үүрэг болон гэрээний ач холбогдол, мөн чанар, гарах үр дүнгийн талаар мэдээ, мэдээлэл бэлтгэн танилцуулан судлуулж, өдөр тутмын үйл ажиллагаанд дадал, зуршил болгон мөрдүүлж, хэвшүүлэх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан.

Тухайлбал:

Нийт алба хаагчдын гэрээний хэрэгжилтийг алба хаагчдын тайлан, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хамт сар бүр дүгнэж, улирал бүр Цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөлөөр хэлэлцүүлж, үнэлэлт дүгнэлт өгч ажилласнаар гэрээний хэрэгжилтийг хангах зохион байгуулалтын арга хэмжээ болсон ба 100-аас доош үнэлгээ авсан алба хаагчдын нэрсийг Захиргааны удирдлагын тасгийн даргад өгч зохих сургалтанд хамруулах, баталгаа авах зэрэг гэрээ зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ ав ажиллаж байна.

Цагдаагийн газрын даргын 2014 оны А/131 дүгээр тушаалаар баталсан “Цагдаагийн газрын дотоод журам”-ын 2 дугаар зүйлийн 2.12 дахь хэсэгт “Тасаг, албадын дарга, ёс журмын эргүүл Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/57 дугаар тушаалаар батлагдсан “Итгэлцлийн гэрээ”-ний хэрэгжилтэнд тавих хяналтыг сайжруулах, гэрээг зөрчсөн зөрчлийг нуун дарагдуулахгүй байх, заалт нэг бүрийг чанд мөрдөн ажиллах талаар алба хаагч нарт үүрэг, ажлын чиглэл өгч, хэрэгжилтийг хангуулна” гэсэн заалтыг оруулах

талаар Цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 4 дэх хуралдаанаар хэлэлцэж, Цагдаагийн газрын даргын 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/30 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Итгэлцлийн гэрээ зөрчсөн 11 алба хаагчид сахилгын шийтгэл оногдуулсан.

7. Сахилга, ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр 7 удаагийн үүрэг, ажлын чиглэл, мэдээллийг өгч үр дүн, биелэлтийг улирал, хагас жилээр тооцож, өргөсөн тангарагтаа үнэнч байх, цагдаагийн алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрмийн хэрэгжилт, алба хаагчийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой 10 төрлийн баталгааг давхардсан тоогоор 700 гаруй алба хаагчаас гаргуулан авч, хэрэгжилтийг хангуулж ажилласан нь алба хаагчдыг сахилга, хариуцлага дээшлэх нэг хүчин зүйл боллоо.

8. Цагдаагийн газрын тасаг, хэсгийн дарга, ёс журмын эргүүлүүд алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж байгаа бөгөөд Цагдаагийн газрын дотоод журмыг зөрчсөн, удирдлагаар өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй, ажлын үр дүн хангалтгүй ажилласан, албаны бэлэн байдал хангаагүй зэрэг үндэслэлээр нийт 251 алба хаагчдад сарын үндсэн цалинг 1-20 хувиар бууруулан олгож, хариуцлага тооцож ажилласнаар сахилга, ёс зүйн зөрчил буурахад болон алба хаагчдын хариуцлага дээшлэхэд шууд нөлөөл үзүүлж байна.

9. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоолын 1.10 дахь заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор Цагдаагийн газрын даргын 2014 оны А/131 дүгээр тушаалаар баталсан “Цагдаагийн газрын дотоод журам”-ын 15 дугаар зүйлийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэгт “Ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдэл гаргахгүй байх”, 15.6 дахь хэсэгт “Цагдаагийн алба хаагч, ажилтнуудаас ажлын байранд ялгаварлан гадуурхах, бэлгийн дарамт гарахаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, энэхүү асуудлаар гаргасан гомдлыг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Ялгаварлан гадуурхах, ажлын байрны бэлгийн дарамтаас хамгаалах /код-922/ журам”-ын дагуу шийдвэрлэнэ” гэсэн заалтыг оруулах талаар Цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 4 дэх хуралдаанаар хэлэлцэж, Цагдаагийн газрын даргын 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/30 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан.

10. Алба хаагчдын сахилга, ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоож, арилгуулах, алба хаагчдын илтгэх үр чадварыг дээшлүүлэх, шинэлэг санал, санаачлагыг үйл ажиллагаанд нэвтрүүлэх зорилгоор алба хаагчдын дунд Цагдаагийн газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 07-ны өдөр баталсан удирдамжийн дагуу “Сахилга, ёс зүйн зөрчлийг бууруулахад алба хаагчийн оролцоо” сэдэвт итгэлийн уралдааныг зохион байгуулсан бөгөөд алба хаагчдын сахилга, ёс зүйг бууруулахад чиглэсэн алба хаагчдын хувийн зохион байгуулалтыг дээшлүүлэх, дүрэмт хувцасыг дүрмийн дагуу өмсөж хэрэглэх, хууль хэрэглэх чадвар, харилцааны соёлыг дээшлүүлэх, зөв хэвшил, хандлагыг төлөвшүүлэх зэрэг алба хаагчдаас дэвшүүлсэн санал санаачлагыг хэрэгжүүлэхээр тогтов.

11. Алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, тэр дундаа сахилга, ёс зүйн зөрчил, дутагдал гаргахад нөлөөлж буй архи согтууруулах ундааны хор нөлөөг таниулан ойлгуулах, зөв хэвшил, хандлагыг бий болгох зорилгоор Цагдаагийн газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 16-ны өдөр баталсан “Хорт зуршлаас татгалзцааг” сэдэвт жүжигчилсэн үзүүлбэрийн тэмцээнийг удирдамжийн дагуу зохион байгуулав.

Тэмцээнд нийт 8 тасаг, хэсгийн 43 алба хаагч идэвх, санаачлага гарган оролцож өрсөлдлөө.

12. Цагдаагийн газрын даргын 2014 оны 131 дүгээр тушаалаар баталсан “Цагдаагийн газрын дотоод журам”-ын дагуу өглөөний нэгдсэн цугларалтыг ямар

нэгэн хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тасалсан тохиолдол бүрт өдөр тутмын албаны бэлэн байдал хангаагүй гэж үзэн, сарын үндсэн цалингаас нь 5 /тав/ хувийг суутгаж, цалинг хасч олгож байгаа бөгөөд алба хаагч, ажилтны цаг ашиглалтыг хурууны хээ болон бүртгэлийн дэвтэрээр давхар бүртгэж, Цагдаагийн газрын тасаг, хэсгийн дарга, ёс журмын эргүүлүүдийн зүгээс алба хаагчдын цаг ашиглалтанд өдөр бүр хяналт тавьж ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд өглөөний яриа тасалсан давхардсан тоогоор 51 алба хаагчын сарын үндсэн цалингаас нь 5 хувь суутгаж, цалинг хасч олгосон бол яриа тасалсан алба хаагчдыг өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 92 алба хаагч буюу 64.3 хувиар буурсан байна.

Цагдаагийн газрын дотоод журмын 2 дугаар зүйлийн 2.5 дахь хэсэгт "...Ажилтнууд тухайн өдөр хийсэн ажлаа 16.00-17.00 цагийн хооронд тасаг, албаны даргадаа танилцуулсны дараа ажлаас бууна..."- гэж заасан нь алба хаагчдын цаг ашиглалтыг сайжруулах, тасаг, хэсгийн дарга нараас алба хаагчдын үйл ажиллагаанд хяналт тавих хяналтыг дээшлүүлэх зохицуулалт болж байна.

13. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А/37 дугаар тушаалаар баталсан "Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын ахмад, дунд, залуу үеийн залгамж холбоог хөгжүүлэх хөтөлбөр", Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дасан зохицох /код 944/ журам"-ын хэрэгжилтийг хангах, шинээр орсон алба хаагчдыг цагдаагийн албанд богино хугацаанд дадлагжуулах, албандаа хандах хандлагыг нэмэгдүүлэх, сахилга, ёс зүйг дээшлүүлэх зорилгоор дотоод нөөц бололцоонд тулгуурлан "Цагдаагийн албанд богино хугацаанд сургах гарын авлага"-ыг боловсруулан Цагдаагийн ерөнхий газрын Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтэст 2019 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 27/3553 дугаартай албан бичгээр хүргүүлсэн бөгөөд сүүлийн 2 жилийн хугацаанд цагдаагийн албанд шинээр томилогдсон алба хаагчдад тараасан болно.

Гарын авлаганд Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм, сахилгын дүрэм, итгэлцлийн гэрээ, Цагдаагийн байгууллагын дотоод албаны дүрмүүдийг тусгаж өгснөөр ач холбогдолтой байна.

14. Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2018 оны А/120 дугаар тушаалаар баталсан "Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын соёлыг төлөвшүүлэх хөтөлбөр, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангах ерөнхий 12 чиглэлийн 35 заалт бүхий ажлын төлөвлөгөөг, мөн даргын 2019 оны А/19 дүгээр тушаалаар баталсан "Соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө"-г хэрэгжүүлэх зорилгоор 28 заалт бүхий ажлын төлөвлөгөөг 2019 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр тус тус баталж, хэрэгжилтийг хангах ажлын хэсгийг 4 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллуулж байна.

15. Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргаас 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 3/74 дүгээр албан бичгээр ирүүлсэн Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд 2019 оны 03 дугаар сарын 01-нээс 06 дугаар сарын 01-ний өдөр хүртэл 90 хоногийн хугацаатай зохион байгуулагдсан "Зөв хэвшил, хандлага" аяныг хүрээнд 15 төрлийн ажил, арга хэмжээг төлөвлөн зохион байгуулж, хэрэгжилтийг 100 хувь хангаж ажилласан.

16. Алба хаагчдын дунд соёл хүмүүжлийн ажлыг алба хаагч, тэдний гэр бүлд хүрсэн, сонирхол татахуйц, мэдлэг, оюун ухаан, соёлыг тэлэхүйц шинэлэг хэлбэрээр 20 удаагийн ажил, арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд давхардсан тоогоор 1100 гаруй алба хаагчийг хамруулсан.

Тухайлбал:

- Цагдаагийн алба болон алба хаагчдын ажлын онцлогийн гэр бүлийн гишүүдэд сурталчлан ойлгуулах, урам зориг өгөх, алба хаагчдын ажлын бүтээмж, гэр бүлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, гэр бүлдээ хандах хандлагыг дээшлүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор 2019 оны 03 дугаар сарын 02-ны өдөр

алба хаагчдын гэр бүлийн гишүүдийн дунд “Гэр бүлийн үнэ цэнэ” сэдэвт сургалт, зөвлөгөөнийг төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу зохион байгууллаа.

Гэр бүлийн сургалт, зөвлөгөөнд алба хаагчид, тэдний гэр бүлийн гишүүд, эмэгтэй алба хаагчид зэрэг нийт 120 хүн хамрагдсан ба сургалт, зөвлөгөөний хөтөлбөрийн хүрээнд Цагдаагийн газрын түүх, бүтэц, зохион байгуулалт болон алба хаагчдын ажлын онцлогийг харуулсан танилцуулгыг танилцуулж, гэр бүлийн гишүүдэд зориулж бичүүлсэн “Чин сэтгэлийн захидал”, “Хишиг өдөр”, “Хак-Чак” хөгжөөнт тэмцээн, “Гэр бүлийн үнэ цэнэ” сэдэвт сургалт, “Сэтгэлийн үг” нэвтрүүлэг, гэр бүлийн гишүүдийн дунд санал, хүсэлтийн “Ярилцлагаа” болон “Халамжит хань”, “Ачлалт ээж” номинацуудыг шалгаруулах зэрэг ажил, арга хэмжээнүүдийг өргөн хүрээнд зохион байгуулав.

- Гэр бүлийн үнэ цэнэ, харьцаа, хандлагыг сайжруулах, урам зоригийг нэмэгдүүлэх зорилгоор алба хаагчдын дунд 2019 оны 02 дугаар сарын 18-28-ний өдрийн хооронд “Гэр бүлдээ бичих чин сэтгэлийн захидал” арга хэмжээг зохион байгуулсан ба нийт 93 алба хаагч гэр бүлдээ чин сэтгэлийн захидлыг гэр бүлийн гишүүдэд хүндэтгэлтэйгээр гардуулж, “Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”-ийн мэндийг дэвшүүлсэн болно.

- Тус Цагдаагийн газрын эрүүлжүүлэх баривчлах байрны жижүүр цагдаа, цагдаагийн дэд ахлагч Н.Энхбаяр 2019 оны 02 дугаар сарын 02-ний өдөр “Жаргалын нутаг” биеэ даасан тоглолтыг аймгийн иргэдэд зориулсан зохион байгуулсан ба уг тоглолтонд Цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүнийг хамруулж, дэмжлэг үзүүлэв.

17. Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2019 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн А/170 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Сахилгын шийтгэл оногдуулах /код-914/ журам”-ын дагуу цагдаагийн газрын алба хаагчдын сахилга, ёс зүйн байдалд болон сахилгын зөвлөгөөн зохион байгуулсан үр дүнгийн үнэлгээг тус тус гаргасан.

18. Сахилгын шийтгэл хүлээсэн 7 алба хаагчдад итгэл найдварын захидал хүргүүлж, давтан сахилгын зөрчил гаргахаас урьдчилан сэргийлж, итгэл найдвар хүлээлгэв.

19. Удирдах ажилтны манлайлал, ажлын арга барилыг сайжруулах, байгууллагын соёлыг төлөвшүүлэх, менежментийн аргуудыг болон шинэлэг санал санаачлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх зорилгоор “Удирдах ажилтны манлайлал, байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд миний оролцоо” сэдэвт эссе бичлэгийн уралдааныг Цагдаагийн газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 07-ны өдөр баталсан удирдамжийн дагуу зохион байгуулсан ба нийт 9 тасаг, хэсгийн дарга оролцсон бөгөөд Цагдаагийн ерөнхий газрын Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтэст 2019 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 27/2141 дугаартай албан бичгээр эссегийн материалыг хүргүүлж, шалгаруулсан болно.

20. Цагдаагийн газрын даргын санаачлагаар зөв хэвшил, хандлагыг бий болгох, алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Өглөөний өлгийчүүд” арга хэмжээг 7 хоног бүрийн Бямба гарагийн 06:00 цагт аймгийн төвд талбайд зохион байгуулж хэвшсэн бөгөөд арга хэмжээнд цагдаагийн алба хаагчдаас гадна аймгийн төвийн иргэд өргөнөөр оролцож байна.

Арга хэмжээнд холбогдох мэргэжлийн хүмүүс карго, аеробик, хийн тайвшруулах зэрэг төрөл бүрийн дасгал хөдөлгөөн хийлгэж, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх болон хорт зуршлаас ангижрах талаар зөвлөгөө өгч байна.

21. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/19 дүгээр тушаалаар баталсан “Соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах, алба хаагчдын авъяас, ур чадварыг дээшлүүлэх, гэр бүлийн гишүүдийн хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор “Цэнгээнт”, “Чөлөөт” бүжиг, “Уран уншлага”-ын тэмцээнийг зохион байгуулж, амжилттай оролцсон алба хаагч, гэр бүлийн гишүүдийг шагнаж, урамшуулав.

22. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Албаны байр, эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавих /код-802/ журам”-ын хэрэгжилтийг хангах, Цагдаагийн газар байгуулагдсаны түүхт 80 жилийн ойг угтаж алба хаагчдаас бүтээлч ажил зохион байгуулах, алба хаагчдын ажиллах орчныг сайжруулах, ажлын бүтээмж, бүтээлч сэтгэлгээг төлөвшүүлэх, шинэлэг арга барил, шинэ санаа дэвшүүлэх зорилгоор “Ажиллах орчноо сайжруулья” сэдэвт уралдааны удирдамжыг Цагдаагийн газрын даргаар 2019 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр батлуулан 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн хооронд зохион байгуулахаар тогтсон бөгөөд уралдааны дүнг 2019 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр ажлын хэсэг дүгнэх юм.

23. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2019 оны соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөний 4 дэх бүлгийн 9 дэх заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор жижиг дунд бизнес эрхэлдэг, эрхлэх сонирхолтой авъяас чадвартай алба хаагч болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн хийсэн бүтээгдэхүүнээр 2019 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр үзэсгэлэн худалдаа гаргав.

1.11. Санхүүгийн үйл ажиллагааны талаар.

1. Цагдаагийн газрын 2019 оны нийт төсөв 2.240.000.000 төгрөг бөгөөд энэ оны эхний 9 сарын байдлаар төсвийн гүйцэтгэл 1.675.075.434 төгрөг буюу 74 хувьтай ба санхүүгийн үйл ажиллагаа болон төсвийн зарцуулалтанд ямар нэгэн зөрчил дутагдал гараагүй бөгөөд Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, журам, зааврыг үйл ажиллагаанд мөрдлөгө болгон ажиллаж байна.

2. Монгол Улсын “Төсвийн тухай хууль”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”, Санхүү эдийн засгийн сайдын 2002 оны “Байгууллагад нийтлэг хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн маягт, түүнийг хөтлөх аргачлал”, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагад мөрдөгдөх мөнгөн кассын ажиллагааны журам”, 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”, ЦЕГ-ын даргын тушаалаар баталсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, Цагдаагийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажилласан.

Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт болон журнал, ерөнхий дэвтэрийг бүрэн хөтөлж, бараа материалын тайлан, үндсэн хөрөнгийн хөдөлгөөний бүртгэл, бусад тайланг сар, улирал бүр гаргаж, цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар сар бүр хэлэлцүүлэн, үр дүнг тооцон, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр засуулан, хөрөнгийн зарцуулалтын тайланг хугацаанд нь үнэн зөв гаргаж, холбогдох газарт хүргүүлсэн.

3. Шийтгэлийн хуудас маягт 1, 2 хуудасны тооцоог төвийн алба хаагч нар ажлын 3 хоногт, хэсгийн төлөөлөгч, цагдаа нар 14 хоногт багтааж санхүүтэй тооцоо хийж, үнэт цаасны тайланг сар бүр нярваар гаргуулан Цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулан үр дүнг тооцож, санхүүгийн зөрчил дутагдал гарахаас урьдчилан сэргийлэн ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газраас ирсэн бараа материал болон систем хооронд тооцоог тооцоо нийлсэн актаар баталгаажуулан ажилласан.

4. Тайлангийн хугацаанд цагдаагийн газрын албаны автомашинуудын бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах зорилгоор цагдаагийн газрын төсвөөс 37 нэр төрлийн 84 ширхэг 6.229.000 төгрөгний үнэ бүхий сэлбэг хэрэгсэл худалдан авч аюулгүй байдал, техникийн бүрэн бүтэн байдлаа хангуулан ажиллаж бөгөөд Цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөлийн хэлэлцэх асуудлын төлөвлөлтийн дагуу сар бүр шатах тослох материалын зарцуулалтын талаар танилцуулж, хяналт тавьж ажиллаж байна.

5. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70, 71, 72, 73 дугаар зүйл, Нягтлан болох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь заалт, Монгол улсын Сангийн сайдын 2016 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 126 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн

тооллого явуулах журам”-ыг тус тус үндэслэн Цагдаагийн газрын 2019 оны эхний хагас жилийн эд хөрөнгийн тооллого явуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Цагдаагийн газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/43 дугаар тушаалаар 5 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй байгуулж, Цагдаагийн газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгөд ажлын 5 хоногт багтааж эд хөрөнгийн тооллого явуулсан.

1.12. Тайлангийн хугацаанд зохион байгуулсан, шинэлэг ажил, арга хэмжээ, түүний үр дүнгийн талаар.

1. Алба хаагчдын оюуны хэрэгцээг хангах, мэдлэг, боловсролыг дээшлүүлэх зорилгоор аймгийн Төв номын сантай “Зөөврийн номын сан ажиллуулах гэрээ”-г 2019 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр байгууллаа.

Зөөврийн номын санд багтсан хууль эрх зүй, гадаад хэл, уран зохиол, шинжлэх ухаан, сонин, сэтгүүл зэрэг нийт 20.000 гаруй ном, сэтгүүл, товхимолыг алба хаагч

2. Аймгийн хэмжээнд замын хөдөлгөөний зөрчлийн илрүүлэлтийг иргэдийн оролцоотой зохион байгуулах, бууруулах, таслан зогсоох, “Иргэн бүр цагдаа” гэсэн уриалгыг хэрэгжүүлэх зорилгоор “TRAFFIK raparatsi Olgii” нэртэй пейж хуудас, “Өлгий Замын цагдаа папарацци” нэртэй фейсбүүк хаяг нээн ажиллуулж эхэлсэн бөгөөд хуудсыг нээж ажиллуулснаар замын хөдөлгөөний дүрэм зөрчиж буй жолооч, иргэдийн зөрчлийг дан ганц цагдаа биш, иргэдийн оролцоотойгоор илрүүлэх боломжтой боллоо.

Өнөөдрийн байдлаар цахим хуудсанд иргэдээс замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн 80 гаруй зураг, мэдээ, мэдээлэл ирүүлснийг шалгаж, замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн 50 гаруй жолоочид хуулийн хүрээнд хариуцлага тооцсон ба энэ нь замын хөдөлгөөний дүрмийн хэрэгжилтийг хангуулах гол хүчин болоод байна.

3. Цагдаагийн газрын тасаг, хэсгийн дарга нар албан тасалгаандаа “Төлөвлөлт, хяналтын самбар”-ыг байршуулж, үйл ажиллагаандаа ашигласнаар Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2019 онд хэрэгжилтийг хангах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, биелэлт үр дүнг тооцох баримт бичгийн хэрэгжилт хангагдахгүй, тогтоосон хугацаанд тайлагнахгүй орхигдуулах, ажлын төлөвлөлт алдагдах зэргээс урьдчилан сэргийлж байна.

4. Байгууллагын соёлд нөлөөлөх үйл, хандлага, сэтгэлгээний чиглэлээр богино хэмжээний видео, бичлэг хүргүүлэх ажлын хүрээнд алба хаагчдын гэр бүлийн гишүүдийн дэмжлэг туслалцааг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх, алба хаагчдын ёс зүй, соёлд нөлөөлөх зорилгоор 9 алба хаагч болон 1 алба хаагчийн нөхөр, 2 алба хаагчийн аавуудыг оролцуулсан “Сэтгэлийн үг”, мөн хөдөлмөрч, бүтээлч, ахуй амьдралаа сайн авч явж байгаа Дотоодын цэргийн тусгай салааны захирагч, хошууч А.Кадирбекийн гэр бүлийг онцлож “Үлгэр жишээч гэр бүл” нэвтрүүлгийг тус тус бэлтгэн орон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон цахим орчинд алба хаагчдад болон иргэд, олон нийтэд сурталчилж ажилласан болно.

Мөн “Сэтгэлийн үг” нэвтрүүлэгт тус цагдаагийн газрын сэтгэл зүйчид гэр бүлийн харьцаа, хандлагын чиглэлээр зөрчилтэй гэх асуудлаар хандсан 5 алба хаагчийг татан оролцуулж, уг нэвтрүүлгээр дамжуулан бие биеэнээ ойлгох, дэмжих, уучлалт гуйх, сэтгэлийн үгээ дамжуулах зэрэг сэтгэл зүйн үйлчилгээ, туслалцааг давхар явуулсан болно.

1.13. Бусад

1. “Цагдаагийн албаны тухай хууль”-ийн 15 дугаар зүйлийн 15.1.6 дахь хэсэг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/133 дугаар тушаал, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Цагдаагийн байгууллага, алба хаагчаас тайлан тавих /код 129/ журам”-ыг тус тус үндэслэн Цагдаагийн газрын 2018 оны тайланг Цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөлийн 2018 оны 34 дүгээр хуралдаанаар хэлэлцэж, аймгийн Засаг даргын тамгын газарт 2019 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 32/36, ИТХ-ын дэргэдэх Иргэний зөвлөлд 2019 оны 01 дүгээр сарын 04-ний

өдрийн 32/35 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлж, аймгийн Засаг даргын өргөтгөсөн зөвлөлийн хуралд 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр, Иргэний зөвлөлд 2019 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр тус тус тайлагнав.

Мөн Цагдаагийн газрын 2018 оны үйл ажиллагааны тайлангийн хурлыг хүн амын төвлөрөл ихтэй Өлгий, Ногооннуур, Улаанхус, Дэлүүн сумдад зохион байгуулсан ба нийт 1000 гаруй хүн оролцсон бөгөөд тайлангийн хурлын үеэр санал, хүсэлтийн хайрцаг ажиллуулж, урлагийн тоглолтыг сонирхуулав.

Цагдаагийн газрын 2018 оны үйл ажиллагааны тайланг видео хэлбэрээр /23 минут/ бэлтгэж, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон Цагдаагийн газрын албаны ёсны цахим хуудас /bayan-ulgii.police.gov.mn/-аар сурталчлав.

Тайлангийн хурлын үер 9 иргэн санал, 37 иргэн цагдаагийн газрын үйл ажиллагаанд талархал илэрхийлэв.

2. Цагдаагийн газраас 2018 онд хэрэгжүүлсэн, ажил, арга хэмжээ, гаргасан ололт амжилт, тэргүүн туршлагыг иргэд, олон нийтэд сурталчлах зорилгоор жил бүр эрхлэн гаргадаг “ӨЛГИЙ-ЦАГДАА” сэтгүүлийн 5 дахь дугаарыг гаргаж, иргэд, олон нийтэд үнэ төлбөргүй тараав.

3. Тус Цагдаагийн газрын "Цагаан шонхор" баг, Цагдаагийн ерөнхий газрын Хүч спорт хорооны багийн харваач цагдаагийн дэд ахлагч Э.Гантөмөр "Мөсөн сур"-ын Улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож 20 сумнаас 19 онож 4-р байранд шалгарч спортын мастерын болзол, цагдаагийн дэд ахлагч Ц.Мөнхбаяр 20 сумнаас 17 онож спортын дэд мастерын болзол хангасан бол дэд ахлагч спортын мастер Б.Энхтүвшин мөн 20 сумнаас 19 онож шагналт байранд шалгарсан сайхан амжилтыг тус цагдаагийн газрын алба хаагч нар үзүүлсэн байна. Уг тэмцээнд Монгол улсын 21 аймаг, спорт хороодын 29 баг, 350 гаруй харваач цэц мэргэнээ сорин өрсөлдлөө.

- Баян-Өлгий аймгийн сурын холбооноос зохион байгуулсан 2019 оны сурын харвааны нээлтийн мөсний сурын харваанд тус цагдаагийн газрын харваачид амжилттай оролцож цуваа харваанд цагдаагийн дэд ахлагч Б.Энхтүвшин 3 дугаар байранд орсон амжилтыг үзүүлсэн.

- Мөн өвлийн аялал жуулчлалын эвент арга хэмжээний хүрээнд Сар шинийн баярыг тохиолдуулан “Көбөш требл” ХХК-аас зохион байгуулсан мөсөн сурын багийн харваанд цагдаагийн газрын “Цагаан шонхор” багийн харваачид амжилттай оролцож 2 дугаар байр эзэлж мөнгөн медалиар шагнагдсан амжилтуудыг тус тус үзүүлсэн.

- Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагуудын 2019 оны аварга шалгаруулах Мөрдөн байцаах албаны нэрэмжит "Уулын унадаг дугуй"-н тэмцээн Улаанбаатар хотод 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулагдсан бөгөөд эрэгтэй 30-39 насны ангилалд тус Цагдаагийн газрын Мөрдөн байцаах тасгийн дарга, цагдаагийн хошууч Н.Дарханбаяр тэргүүн баяр эзэлж, цом, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдав.

- Нийслэлийн цагдаагийн газраас 2019 оны 03 дугаар сарын 26-наас 28-ны өдрүүдэд зохион явуулсан Цагдаа, Дотоодын цэргийн 2019 оны “Сагсан бөмбөг”-ийн аварга шалгаруулах тэмцээнд эрэгтэй 56 баг оролцоноос тус Цагдаагийн газраас Мөрдөн байцаах тасгийн дарга, цагдаагийн хошууч Н.Дарханбаяр ахлагчтай баг тамирчид шилдэг 8 багт шалгарсан амжилт гарган оролцож, Дотоодын цэргийн захирагч А.Кадирбек “Сагсан бөмбөг”-ийн спортын мастер цол тэмдгээр шагнагдсан болно.

- Аймгийн 2019 оны аварга шалгаруулах “Ширээний теннис”-ийн багийн төрөлд тус Цагдаагийн газрын МХГХТХ-ийн дарга, цагдаагийн хошууч Т.Ердос амжилттай оролцож, багаараа тэргүүн байр эзэлсэн амжилт гаргасан.

- Цагдаагийн газрын харуулын цагдаа, цагдаагийн дэд ахлагч Х.Бекнур нь БНХАУ-ын Сычуань мужийн Чезэндү хотод зохион байгуулагдсан Дэлхийн цагдаа, галын олимпид Монгол Улсын цагдаа, дотоодын цэргийн байгууллагын нэрийг

дэлхийн тавцанд өндөрт өргөж, каратегийн -90 кг жинд алтан медаль, Боксын 90 кг жинд мөнгөн медаль хүртэн өндөр амжилт үзүүлсэн.

- Цагдаагийн газрын 1 дүгээр улирлын нэгдсэн сургалтын үеэр алба хаагч нарын дунд буудлагын “Скат” төхөөрөмж дээр гар бууны /ПМ буугаар/ тэмцээн зохион байгуулав.

4. Алба хаагчдын үйл ажиллагааг идэвхжүүлэх, ажлын үр дүн, бүтээмжийг дээшлүүлж албандаа хандах итгэл үнэмшлийг нэмэгдүүлэх зорилгоор сар бүр Цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөлөөр хэлэлцэн “Онцлох алба хаагч”-ийг удирдамжийн дагуу шалгаруулж, Цагдаагийн газрын bayan-ulgii.police.gov.mn веб сайт, “Баян-Өлгий Цагдаагийн газар” facebook цахим хаягуудаар иргэд, олон нийтэд сурталчлан ажиллаж байна.

5. Соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу алба хаагчдын дунд “Би цэвэр бичигтэн” хичээнгүй бичих уралдааныг 2019 оны 03 дугаар сарын 12-ны баталсан удирдамжийн дагуу 2 үе шаттай зохион байгуулсан.

Нэгдүгээр үе шатыг нийт бие бүрэлдэхүүний дунд А4 хэмжээтэй бичгийн цаасанд Цагдаагийн тангараг, Монгол улсын төрийн дуулалыг хар өнгийн тосон балаар цэвэр, гаргацтай хичээнгүй бичүүлж, үүнээс 10 алба хаагчийг шалгаруулж, шалгарсан 10 алба хаагч хоёрдугаар шатанд монгол хэлний дүрэм, бичгийн эмх цэгц, хичээнгүй бичих чиглэлээр өрсөлдөж, эхний 3 байранд шалгарсан алба хаагчдын сарын үндсэн цалинг 5-15 хувиар тус тус нэмж, урамшуулав.

6. Цагдаагийн Ерөнхий газраас санаачлан улсын хэмжээнд зохион явуулж буй “Зөв тусгал” аяны хүрээнд тус аймаг дахь Цагдаагийн газар, “Сансар” хүүхдийн дэлгүүртэй хамтран 2019 оны 05 дугаар сарын 26-ны өдөр хүүхдүүдийн дунд “Унадаг дугуй”, “Хийлдэг морины уралдаан”, “Ролик”, “Аав, ээж, би” зэрэг тэмцээнүүдийг зохион байгуулав.

7. Хэсгийн төлөөлөгч нарын мэдлэг, ур чадварыг сайжруулах, ажлын үр дүнг дээшлүүлэх, албандаа хандах эерэг хандлагыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг нь олон нийтэд сурталчлах зорилгоор хэсгийн төлөөлөгч нарын дунд 2019 оны 09 дүгээр сарын 21, 22-ны өдрүүдэд “Шилдэг хэсгийн төлөөлөгч” шалгаруулах тэмцээн зохион байгууллаа.

Шилдэг хэсгийн төлөөлөгч шалгаруулах тэмцээний хүрээнд мэргэжлийн ур чадвар, хууль, эрх зүйн мэдлэг, гадаад хэлний мэдлэг, компьютерийн мэдлэг, албаны галт зэвсэг хэрэглэх ур чадвар, буудлага хийх, бие бялдрын бэлтгэлжилт, тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх ур чадвар, мал зүслэх, шүдлэх, им тамгыг нэрлэх, морь эмээллэх, унах ур чадвар, тээврийн хэрэгсэл жолоодох ур чадвар зэрэг нийт 16 төрлийн шалгалт авч дүнг нэгтгэв.

8. Цагдаагийн газрын төв байрны урьд 2.32*3.0 метрийн хэмжээтэй 30.000.000 төгрөгөний өртөгтэй “LED” дэлгэцийг байрлуулж, үйл ажиллагаанд ашиглаж байна.

**Хоёр: Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах,
олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
чиглэлээр**

2.1. Эрүүгийн цагдаагийн албаны чиглэлээр:

1. Эрүүгийн цагдаагийн тасгаас 2019 оны 3 дугаар улиралд 189 холбогдогчтой, 2.958.330 төгрөгний хохиролтой, 715 хэрэг, үйлдлийг илрүүлэн эрүүгийн хэрэг үүсгэн, яллагдагчаар татах саналтайгаар прокурорт шилжүүлсэн ба үүнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 635 хэрэг, үйлдлээр буюу 8 дахин өссөн үзүүлэлттэй байна.

2. Тус цагдаагийн газраас эрэн сурвалжлах “ASAP” санд Сураггүй алга болсон хүн: урьд оны зарлагдсан 6, энэ онд зарлагдсан 16 байснаас 17 хүнийг олж тогтоож ажилласан ба одоогийн байдлаар урьд оны үлдэгдэл 4, энэ оны зарлагдсан хүн 1, нийт 5 хүн эрэн сурвалжлагдаж байна.

Одоогийн байдлаар тус цагдаагийн газраас эрэн сурвалжлагдаж байгаа оргодол, хэн болох нь тодорхойгүй цогцос, түүх соёлын дурсгалт зүйлс, химийн бодис байхгүй болно.

Цагдаагийн газрын алба хаагчид давхардсан тоогоор нийт 5013 удаа эрэн сурвалжлах “ASAP” сангаар зарлагдсан мэдээлэлтэй орж танилцсан ба үр дүнд бусад Цагдаагийн газар, хэлтсээс эрэн сурвалжлагдаж байсан 29 гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдийг олж тогтоон харьяа газар, хэлтсүүдэд хүлээлгэн өгсөн байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Эрэн сурвалжлах код-229 журам”-ыг хэрхэн ашиглах, зөрчил дутагдал гаргуулахгүй байх үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах талаар 4 удаагийн 5 цагийн хичээл сургалт явуулж давхардсан тоогоор нийт 215 алба хаагч хамрагдсан.

3. Тодорхой төрлийн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор 11 төрлийн хэсэгчилсэн арга хэмжээг төлөвлөгөөний дагуу зохион байгуулан үр дүнг тооцсон. Тухайлбал:

Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан, зогсоох, илрүүлэх зорилгоор “Хөрөө Рам” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулсан. Уг арга хэмжээний хүрээнд хөрөө, рам ажиллуулдаг гэх 15 иргэнийг бүртгэл судалгаанд авч хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийн хор уршиг, хариуцлага, урьдчилан сэргийлэх талаар яриа таниулга хийсэн. Тайлангийн хугацаанд хууль бусаар мод бэлтгэсэн гэх 3 холбогдогчтой 3 хэрэг, үйлдлийг илрүүлэн шалгасан.

Мөн мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх зорилгоор “Гарал үүсэл”, “Орон нутаг”, “Малын сэг зэм”, “Хяналт шалгалт” зэрэг нийт 4 удаагийн хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгууллаа.

Арга хэмжээний хүрээнд хамтарсан багийн гишүүд болох багийн Засаг дарга, Хэсгийн төлөөлөгч, өрхийн эмч нарт “Бэлгийн хүчирхийлэл ба хүүхэд” сэдэвт яриа хийсэн. Сар шинийн баярын үеэр зохион байгуулагдсан “Сар Шинэ” нэгдсэн арга хэмжээний хүрээнд урьд нь цагдаагийн байгууллагад бүртгэгдээгүй 97, ажиллагааны явцад 26 хэрэг, үйлдлийг нөхөн илрүүлсэн ба гэмт хэрэгт сэрдэгдсэн 19 этгээдийг олж баривчилсан.

Одоогийн байдлаар “Улсын дугаар-2019”, “Бүртгэл хяналт-2”, “Эко-2019” зэрэг нэгдсэн арга хэмжээнүүдийг аймгийн хэмжээнд зохион явуулан ажиллаж байна.

4. Цагдаагийн газрын даргын 2019 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А/10 дугаартай тушаалаар тус цагдаагийн газраас МУ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Засгийн газрын 346 дугаар тогтоолоор батлагдсан “Гэрч хохирогчийг хамгаалах туслалцаа үзүүлэх” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах чиглэл хариуцан ажиллах үүрэг бүхий алба хаагчийг томилуулсан.

“Гэрч, хохирогчийг хамгаалах туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажил арга хэмжээ”-ний хүрээнд 2019 онд хэрэгжүүлэх 15 заалт бүхий ажлын төлөвлөгөөг 2019 оны 02 дугаар сарын 11-ний өдөр батлан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

“Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах ажлыг өөрийн байгууллагын хэмжээнд бодлого арга зүйн хүрээнд чиглэл хариуцан хэрэгжүүлэхээр томилогдсон алба хаагчдыг мэргэшүүлэх сургалтад хамруулж, гэрч хохирогчийг хамгаалах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэхэд ашиглагдах нэг бүрийн 375.000 төгрөгийн үнэ бүхий байршил тогтоогч /GPS/ төхөөрөмж 3 ширхгийг хүлээн авч Эрүүгийн цагдаагийн тасагт ашиглаж байна.

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр:

1. Тус Цагдаагийн газарт 2019 оны эхний 8 сарын байдлаар нийт 218 гэмт хэрэг бүртгэгдэж, үүнд нийт 174 хүн холбогдон шалгагдсан, гэмт хэргийн улмаас иргэн аж ахуй нэгж байгууллагад 730.9 сая төгрөгний хохирол учирсан ба учирсан хохирлын 354.7 сая төгрөгийг буюу 48.5 хувийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд барагдуулсан.

Нийт бүртгэгдсэн 233 гэмт хэргийн 5 буюу 2.1 хувийг малын хулгай гэмт хэрэг

эзэлж байгаа нь өнгөрсөн жилийн мөн үеийн түвшнгээс малын хулгайлах гэмт хэрэг 10 хэргээр буюу 66.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцогдвол зохих этгээд нь тогтоогдоогүй 4 мал хулгайлах гэмт хэргээс 2 хэргийн эзэн холбогдогчийг олж тогтоон яллах дүгнэлт үйлдүүлэхээр прокурорт шилжүүлсэн, одоо эзэн холбогдогч нь тогтоогдоогүй 2 хэрэг байгаа бөгөөд илрүүлэлт 50 хувьтай байна.

Үйлдэгдсэн мал хулгайлах гэмт хэргийг өнгөөр нь авч үзвэл 4 хөнгөн гэмт хэрэг, 1 хүнд гэмт бүртгэгдсэн.

2. Мал хулгайлах гэмт хэрэгт явуулах мөрдөн шалгах ажиллагааг богино хугацаанд чанартай хийж гүйцэтгэх, эзэн холбогдогч нь тогтоогдоогүй хэргийн илрүүлэлтийг ахиулах чиглэлээр эрүүгийн мөрдөгч, сум хариуцсан эрүүгийн мөрдөгч нарт энэ оны 01, 02, 03, 04, 05, 06 дугаартай зааварчилга, 2019 оны 04 дүгээр сарын 19-ны өдөр 32/1517, 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдөр 27/2337 дугаартай албан бичгээр “Үүрэг, ажлын чиглэл”, сумдын Засаг дарга нарт 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр 116, 117, 118, 119, 120 дугаартай “Албан шаардлага”-ыг тус тус хүргүүлэн хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

Мал хулгайлах гэмт хэрэгт холбогдон шалгагдсан болон, энэ төрлийн гэмт хэрэгт ял шийтгүүлсэн гэх нийт 138 сэжигтэй этгээдийн судалгааг гаргаж, тэдгээрийн хаягийн бүртгэлийг тухай бүр гаргаж ажиллав.

3. Аймгийн ИТХ-ын тэгүүлэгчдийн 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 60 дугаартай тогтоолоор мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх “Дэд зөвлөл”-ийг байгуулан хийж хэрэгжүүлэх ажлын 26 заалт бүхий төлөвлөгөө гаргаж, холбогдох ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

4. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэсгээс 8 удаа орон нутгийн “9 мэдээ” радиогоор, орон нутгийн “Саян-ТВ”, “Дербес-ТВ”-ээр тус бүр 11 удаа малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр сэрэмжлүүлэг, нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэж, иргэд, олон нийтэд хүргэж, ард иргэд, малчдад нийт 950 ширхэг санамж, сэрэмжлүүлэг бэлтгэж тараасан.

Мал, малын гаралтай түүхий эдийн тээвэрлэлт, нядалгаа, худалдаалах үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах зорилгоор Нийтийн хэв журам хамгаалах тасаг болон Замын цагдаагийн тасагтай хамтран хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулж мал, амьтны эрүүл мэнд-гарал үүслийн гэрчилгээний журам зөрчсөн 5 зөрчлийг илрүүлж, Зөрчлийн тухай хуулийн 13.5 дахь заалтаар 5 хүнийг нийт 750.000 төгрөгөөр торгож арга хэмжээ авсан.

5. Хил залгаа Ховд, Увс аймаг дахь Цагдаагийн газрын Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэсгийн алба хаагч нартай байнгын утсаар холбогдож, аймаг, орон нутаг дамжин мал хулгайлах гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдүүдийн талаар мэдээ, мэдээлэл солилцон, Баян-Өлгий аймгийн харьяат, орон нутаг дамжин мал хулгайлах гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдийн судалгаанд баяжилт хийж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

6. Мөн хөдөө орон нутагт Ногооннуур, Улаанхус, Баяннуур сумуудад ажиллаж байгаа малчдын бүлгийн үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор 3 удаа уулзалт зохион байгуулж, мэдээ, мэдээлэл солилцож ажилласан.

7. Цагдаагийн газрын даргын 2019 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр баталсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэсэг, Улаанхус сумын ГХУСАЗСЗ, Улаанхус сум дахь Цагдаагийн хэсэг хамтран 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр Улаанхус сумын Хөх хөтөл багийн төвд Монгол Улсын Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, хил дамнасан мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах, малчдын бүлгэмийн гишүүдийг чадавхжуулах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор “Хил дамнасан мал хулгайлах гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж байгаа асуудал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ” сэдэвт сум дундын сургалт, зөвлөгөөнийг зохион байгууллаа.

Сургалт, зөвлөгөөнд Цагааннуур тосгон, Цэнгэл, Улаанхус, Ногооннуур сумын удирдлагууд, багийн Засаг дарга, Хэсгийн төлөөлөгч, малчдын бүлгэмийн гишүүд зэрэг нийт 90 гаруй хүн оролцов.

Зөвлөгөөнийг зохион байгуулснаар хил орчимд оршин сууж байгаа иргэд, цагдаагийн байгууллагын хамтын ажиллагаа болон иргэдийн хариуцлага дээшилж, хил дамнасан мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэхэд Цагдаагийн байгууллага, Хил хамгаалах байгууллага, сумын удирдлагуудын хоорондын ажлын уялдаа холбоонд ахиц гарч, хил дамнасан мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх ажилд ахиц гарахад ач холбогдолтой.

8. Цагдаагийн газрын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 52 дахь заалтын хэрэгжилтийг хангах, аймаг дамжин үйлдэгдэж буй мал хулгайлах болон бусад төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэхэд хил залгаа сумдын хэсгийн төлөөлөгч нарын хамтын ажиллагааг сайжруулах, туршлага судлуулах, цаашид авч хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний талаар санал солилцох зорилгоор Цагдаагийн газрын даргын 2019 оны 06 дугаар сарын 13-ны өдөр баталсан төлөвлөгөөний дагуу Баян-Өлгий, Увс, Ховд аймгийн хил залгаа сумдын “Хэсгийн төлөөлөгч нарын дунд бүс”-ийн сургалт, зөвлөгөөнийг Эрүүгийн цагдаагийн албанаас өгсөн зөвшөөрлийн дагуу 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдөр Цагдаагийн газарт зохион байгууллаа.

Сургалт, зөвлөгөөнд тус аймгийн Ногооннуур, Баяннуур, Толбо, Дэлүүн, Булган, Увс аймгийн Өлгий, Бөхмөрөн, Ховд, Өмнөговь, Ховд аймгийн Ховд, Эрдэнэбүрэн, Мөнххайрхан, Дуут, Мянгад сумдын хэсгийн төлөөлөгч нар хамрагдсан бөгөөд аймаг дамжин үйлдэгдэж буй мал хулгайлах болон бусад төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх, хил залгаа сумдын хэсгийн төлөөлөгч нарын хамтын ажиллагаа сайжрах, харилцан мэдээ, мэдээлэл солилцох замаар шуурхай ажиллагаа хангагдах, шинэлэг санал, санаачлага гаргах, туршлага нэвтрүүлэх, цаашид авч хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний талаар нэгдсэн ойлголттой болоход чухал ач холбогдолтой арга хэмжээ боллоо.

9. Хилийн 0165, 0285 дугаар ангиудтай харилцан хамтран ажиллах талаар төлөвлөгөө гарган батлуулж, төлөвлөгөөний дагуу байнга мэдээ, мэдээлэл солилцон хамтран ажиллаж байгаа бөгөөд Хилийн цэргийн 0285 дугаар ангийн Хилийн албаны алба хаагч нартай хамтран 2 удаа малын хулгайн гэмт хэрэг ихээр үйлдэгддэг Цагааннуур тосгон, Улаанхус, Ногооннуур сумын малчидтай уулзаж, малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа таниулга хийж, санамж бичиг тараасан.

12. “Хууль зүйн сайд, Хүнс хөдөө аж ахуйн сайдын 2016 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хамтарсан А/160, А/73 дугаар тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгуулагдсан нийт 82 “Малчдын бүлгэм”-ийн үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжлийн удирдлагаар ханган, Алтай, Улаанхус сумын удирдлагуудтай хамтран Улаанхус сумын малчдын бүлгэмийн гишүүдтэй 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр, Алтай сумын малчдын бүлгэмийн гишүүдтэй 2019 оны 05 дугаар сарын 18-ны өдөр тус тус уулзаж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн бөгөөд идэвх санаачлагатай ажиллаж буй малчдын бүлгэмийн 6 гишүүнийг аймгийн ИТХ-ын “Жуух бичиг”, аймгийн “Хүндэт тэмдэг”, “Тэргүүний ажилтан” зэрэг шагналаар шагнаж, урамшуулав.

2.2. Мөрдөн байцаах албаны чиглэлээр:

1. Мөрдөн байцаах тасаг иргэд, аж ахуй нэгж, байгууллагаас гэмт хэргийн талаарх 145 гомдол, мэдээлэл хүлээн авч хуульд заасан үндэслэл, журмын дагуу хойшлуулшгүй ажиллагаа явуулж шалгасан ба нийт гомдол, мэдээллийн 115 хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 22 хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 2 гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлсэн, 6 гомдол мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах саналтайгаар тус тус шийдвэрлэсэн.

2. Нийт хүлээн авч шалгасан гэмт хэргийн талаарх гомдол мэдээллийг 100 хувь шийдвэрлэж, тайлангийн хугацаанд гомдол мэдээлэл шалгах хугацаа хэтрүүлсэн зөрчил дутагдал гараагүй.

3. Мөрдөн байцаах тасаг нь 2019 оны эхний 9 сарын байдлаар 92 хүнд холбогдох, 115 үйлдэлтэй, 152 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, 65 хүнд холбогдох 58 үйлдэлтэй 41 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлж, 49 хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай, 11 хэргийг нэгтгэж, одоо 18 хүнд холбогдох 51 хэргийн үлдэгдэлтэй, нийт шалгасан мөрдөн байцаалтын хэргийн 88,8 хувийг шийдвэрлэсэн.

4. Тайлангийн хугацаанд тус тасгийн мөрдөгчид 81 хэрэг бүртгэлтийн хэрэг хүлээн авч мөрдөн шалгах ажиллагаа явуулсан.

5. Хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулсан 85 хүнд холбогдох 81 үйлдэлтэй 65 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татах санал прокурорт хүргүүлэн шийдвэрлэсэн ба 16 хэргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.14 дүгээр зүйлд заасан үндэслэлээр хаах саналтай шилжүүлж, 5 хүнд холбогдох 8 үйлдэлтэй 3 хэргийг харьяаллын дагуу шилжүүлэн, нийт 152 хэрэг бүртгэлтийн хэргийг шалгаж шийдвэрлэсэн байна.

6. Одоо тус тасагт 29 хэргийн үлдэгдэлтэй бөгөөд урьд оны үлдэгдэлтэй хэргүүдийг 100 хувь, нийт шалгасан хэрэг бүртгэлтийн хэргийн 88,9 хувийг тус тус шийдвэрлэсэн байна.

7. Хэрэг бүртгэлт явуулсан хэрэгт ажилласан мөрдөгчийн тоог дундажлахад 1 мөрдөгч 3,2 хэрэг, мөрдөн байцаалт явуулсан хэрэгт ажилласан мөрдөгчийн тоог дундажлахад 1 мөрдөгч 3.2 хэрэгт мөрдөн байцаалт явуулсан байна.

Мөн прокуророос нэмэлт мөрдөн байцаалтанд буцаасан 8, шүүхээс буцсан 3 хэргийг хүлээн авч мөрдөн байцаалтын ажиллагааг явуулж дахин шийдвэрлэсэн ба прокурор, шүүхээс буцсан хэрэг нийт шалгасан хэргийн 7.2 хувийг эзэлж байна.

8. Нийт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын 152 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 11 хэрэг прокурор, шүүхээс буцсан нь нийт шалгасан хэргийн 7.2 хувийг эзэлж, 1 мөрдөгч дунджаар 3,2 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан байна.

9. Тайлангийн хугацаанд 9 хүнд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч цагдан хоригдсон яллагдагч нартай тасгийн дарга 14 хоног тутамд уулзаж санал хүсэлтийг нь сонсож, тухай бүрт шийдвэрлэсэн.

10. Мөрдөн шалгах ажиллагааг харьяаллын бус байгууллагаар хийлгэх тухай мөрдөгчийн санал бичиж, прокурорын байгууллагад 18-г хүргүүлэн биелэлтийг тооцон ажилласан ба бусад газраас мөрдөн шалгах ажиллагааг харьяаллын бус байгууллагаар хийлгэх тухай прокурорын даалгавар 18-г хүлээн авч хуулийн хугацаанд биелэлтийг тооцож хүргүүлсэн байна.

11. "Able" программд мөрдөгч нарын өдөр тутам үйлдсэн мөрдөн шалгах ажиллагааны тогтоол, тэмдэглэл, мэдүүлэг, бусад ажиллагаануудыг шивж буй эсэхэд тасгийн даргын зүгээс өдөр тутам хяналт тавьж, мөрдөгч нарын ажил дүгнэх шалгуур үзүүлэлтийн нэг бүрдэл хэсэг болгож, биелэлтийг нь сарын эцэст үнэлэлт, дүгнэлт өгч ажиллаж байна.

2.3. Хэрэг бүртгэх албаны чиглэлээр:

1. Хэрэг бүртгэх тасаг нь эхний хагас жил, 1, 2, 3 дугаар улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг Цагдаагийн ерөнхий газар, Хэрэг бүртгэх алба, Цагдаагийн газрын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас дэвшүүлсэн зорилт, Хэрэг бүртгэх албаны даргаас өгсөн үүрэг, даалгавар, ажлын чиглэл зэрэгт нийцүүлэн боловсруулж, 49 ажил арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөн Цагдаагийн газрын даргаар баталгаажуулан хэрэгжилтийг ханган ажилласан.

Төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээнээс огт биелээгүй, тасарсан ажил арга хэмжээ байхгүй бөгөөд эхний 9 сарын байдлаар жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 92.5 хувьтай байна.

2. Иргэд, байгууллага, хуулийн этгээдээс ирүүлсэн гэмт хэргийн шинжтэй 111 гомдол, мэдээлэл хүлээн авч, 30 гомдол, мэдээллийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 75 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 6 гомдол, мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж шийдвэрлэсэн.

Хугацаа хэтрүүлэн шалгасан гомдол, мэдээлэл байхгүй.

Гомдол, мэдээлэл гаргасан иргэд, аж ахуйн нэгжид 100 хувь бичгээр хариу өгсөн.

Хэрэг бүртгэлтийн урд оны үлдэгдэл 12, энэ оны дугаартай 75, нийт 87 хэрэг шалгасан. Үүнээс 68 хэрэг бүртгэлтийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татаж, 13 хэргийг хааж, 2 хэргийг харъяаллын дагуу шилжүүлэн тус тус шийдвэрлэсэн.

Мэдээ гарах үед 4 хэргийн үлдэгдэлтэй байсан.

Хэрэг бүртгэлтийн урд оны дугаартай хэргийн илрүүлэлт 83.3 хувь, энэ оны дугаартай хэргийн илрүүлэлт 93.7 хувь, урд оны дугаартай хэргийн шийдвэрлэлт 92.1 хувь, энэ оны дугаартай хэргийн шийдвэрлэлт 95.1 хувьтай байна.

Мөн энэ хугацаанд мөрдөн байцаалтын 74 хэрэг шалгаж, 65 хэргийг шүүхэд шилжүүлж, 5 хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн. 4 хэргийн үлдэгдэлтэй гарсан. Үүнээс нийт шүүхэд шилжүүлсэн хэргээс 28 хэрэг буюу 43 хувийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн. Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн хэргийн тоо өмнөх оноос 19 хэргээр өссөн.

Мөрдөн байцаалтын хэргийн шийдвэрлэлт 94.5 хувьтай байна.

Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид учирсан 38.888.430 төгрөгийн хохирлоос 38.693.430 төгрөг буюу 99.5 хувийг нөхөн төлүүлж, 7.3 сая төгрөгийн эд хөрөнгө битүүмжилсэн.

3. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэсэгчилсэн арга хэмээ 3 удаа, хэлэлцүүлэг, зөвлөгөөн 4 удаа зохион байгуулсан.

Хэрэг бүртгэх албанаас хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шалтгаан нөхцлийг арилгах, иргэд олон нийтийн оролцоо, дэмжлэгийг нэмэгдүүлэх зорилгоор санаачлан зохион байгуулж байгаа “Нэг хором” аянд тус аймагт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан, алба хаагч, иргэд, дээд сургууль, ерөнхий боловсролын сургуулийн оюутан, сурагчдыг элсүүлсэн.

Нийтдээ уг арга хэмжээнд 31 байгууллага, аж ахуйн нэгж хамрагдаж, 765 хүн нэгдсэн.

“Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг”-ийн ойлголт, хор уршиг, хариуцлага, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 31 удаа 47 байгууллага, аж ахуйн нэгжийг хамруулан 1891 иргэнд хууль сурталчлах яриа, таниулга, сургалт зохион байгуулсан.

“Хүүхэд” арга хэмжээг хэрэгжүүлэх салбар төлөвлөгөөний дагуу хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагч, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан мэргэжилтэн нартай хамтран 2019 оны 09 дүгээр сарын 05-ны өдрөөс 09 дүгээр сарын 13-ны өдрийг хүртэлх хугацаанд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төрийн болон хувийн хэвшлийн ерөнхий боловсролын 43 сургуулийн сурагч, багш, ажилчдад “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас хүүхэд хохирох, холбогдохоос урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Сургалтанд 462 багш, 98 ажилтан, 2654 сурагч, нийтдээ 3214 хүн хамрагдсан байна. Мөн багш, сурагчдад Цагдаагийн газраас гаргасан 3 төрлийн 500 ширхэг сэрэмжлүүлэг хуудас, 1 төрлийн гарын авлага тараасан.

Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтээс ирүүлсэн 21 төрлийн шторк, ярилцлага, нэвтрүүлгийг Цагдаагийн газрын лед дэлгэц, орон нутгийн телевиз, олон дагагчтэй пэйж хуудсаар иргэд, олон нийтэд сурталчилсан.

Тус тасгаас гэмт хэрэг, зөрчил үйлдэгдсэн, үйлдэгдэж болзошгүй шалтгаан, нөхцөлийг тогтоож, тэдгээрийг арилгуулах талаар иргэн, хуулийн этгээдэд хуулиар хүлээсэн үүргийнх нь хүрээнд мөрдөгчийн 46 мэдэгдэл бичиж, 100 хувь хариуг хугацаанд нь авсан.

Дээрх арга хэмжээг зохион байгуулснаар хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн гаралт өмнөх оны мөн үеэс 16.8 хувиар буурсан эерэг үзүүлэлт гарсан.

2.4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

1. Цагдаагийн ерөнхий газрын 2018 оны А/177 дугаар тушаалаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх цагдаагийн байгууллагын бодлогын баримт бичиг, баримт бичгийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг тус тус баталсан бөгөөд тус цагдаагийн газраас бодлогын баримт бичиг, төлөвлөгөөг хэрэгжүүлэх салбар төлөвлөгөөг 2018 оны 07 дугаар сарын 17-ны өдөр цагдаагийн газрын даргаар батлуулж гэмт хэрэгтэй тэмцэх бодлогын 4 чиглэлийг тодорхойлж хэрэгжилтийг нь хангуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж байна.

2. Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн хурлаар салбар зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг ерөнхий арга хэмжээ, тусгай арга хэмжээ, сургалт зөвлөгөөн, сонсгол, сурталчилгаа гэсэн 4 чиглэлээр баталж, төлөвлөгөөнд цагдаагийн байгууллага хамтран хэрэгжүүлэхээр 11 төрөл арга хэмжээний хэрэгжилтийг өнөөдрийн байдлаар 88 хувьтай хэрэгжилтийг хангав.

3. “Цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын 2019 оны төлөвлөгөө”, аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэж, Цагдаагийн газрын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 41 заалт бүхий ажлын төлөвлөгөөг 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдөр баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

4. Цагдаагийн газрын судалгааны баг нь аймгийн нутаг дэвсгэрт бүртгэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судалж, арилгуулах талаар гаргасан санал, зөвлөмжийг Цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөлийн 3 дахь хуралдаанаар хэлэлцэн баталж, хэрэгжүүлэх зорилгоор 24 заалт бүхий ажлын төлөвлөгөөг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр баталж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Цагдаагийн газрын даргын 2019 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/07 тоот тушаалаар эргүүлийн нэгдсэн байршилтыг шинэчлэн баталж, эргүүлийг гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг, хүн амын суурьшил, хөдөлгөөн ихтэй газруудад томилон ажиллуулж, тасгийн дарга, ахлах байцаагч нар хяналт тавин ажиллаж байна. Эргүүлийг өдөр болон оройн цагийн хуваариар, баяр, наадам, тэмдэглэлт өдөр, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэглэлд шилжин ажиллаж байгаа үед 24 цагийн хугацаанд тодорхой цагийн хуваариар томилон ажиллуулж байна.

5. Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга буюу ИТХ-ын даргад Өлгий, Бугат сумдад томилогдсон 7 олон нийтийн цагдаагийн урамшлыг шийдвэрлүүлэх, Баяннуур, Алтанцөгц, Буянт, Алтай, Булган, Толбо, Ногооннуур сумдад олон нийтийн цагдаагийн орон тоог батлуулах тухай 2019 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 32/1219 дугаартай танилцуулга 1, Хил дамнасан мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хил орчмын нутаг дахь айл, өрхийн бод малыг цахим бүртгэлд хамруулж зурагжуулах талаар танилцуулга 1, 2019 онд аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх “Соёлтой жолооч” дэд хөтөлбөрийг батлуулах талаар танилцуулга 1, Улсын хэмжээнд зохион явагдаж буй “Яараад яахав дээ” аяны хүрээнд сурталчилгааны самбарын санхүүжилтийг шийдвэрлүүлэх талаар танилцуулга 1, Улсын хэмжээнд зохион явагдаж буй “Зөв тусгал” аяныг аймгийн хэмжээнд өрнүүлэх талаар танилцуулга 1, “Байгалиа

хамгаалъя” нэгдсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулах талаар танилцуулга 1, “Эрүүл зан үйлийг дэмжсэн архидалтгүй аймаг Баян-Өлгий” дэд хөтөлбөрийг батлуулах талаар танилцуулга 1, аймгийн төв Өлгий сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 32/190 дугаартай албан тоотоор бүх төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр танилцуулга 1, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр танилцуулга 1, 2019 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 32/744 дугаартай албан тоотоор гэр бүлийн хүчирхийлэл болон архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр 1, 2018 онд хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг их бүртгэгдсэн тус аймгийн Баяннуур, Ногооннуур, Цэнгэл, Дэлүүн сумдад сумын ГХУСАЗСЗ-д энэ төрлийн гэмт хэргийг буруулах талаар танилцуулга 4, нийт 16 санал бүхий 14 танилцуулгыг хүргүүлснээс 78 хувийг шийдвэрлэсэн.

6. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол-3, хөтөлбөр-2, нийт 5 шийдвэр гаргуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

7. Шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр орон нутгийн төсөвт нийт 408.030.500 төгрөгийн торгуулийн мөнгийг тушаасан боловч тушаасан мөнгөний 40 хувьтай тэнцэх хэмжээний 163.212.200 төгрөгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардалд тусгаж өгөөгүй.

8. Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон бусад төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд нийт 44030000 төгрөг шийдвэрлэж өгсөн.

9. Цагдаагийн газрын даргаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр өгсөн 13 төрлийн үүрэг, даалгавар, зааварчилгааны биелэлтийг 100 хувь хэрэгжүүлж, үр дүнг тооцон ажилласан.

10. Цагдаагийн газраас аймгийн нутаг дэвсгэрт бүртгэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалд уялдуулан нийт 18 удаа хэсэгчилсэн арга хэмжээ, 13 удаагийн нэгдсэн үзлэг шалгалт, 64 удаа сургалт, мэдээлэл, сурталчилгаа, 9 удаа уулзалт, хэлэлцүүлэг, ярилцлага, 11 удаа өдөрлөг, 4 удаа уралдаан, тэмцээн зэргийг орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотой зохион байгуулсан бөгөөд нийт 8606 хүн хамрагдав.

11. *Ухуулга, яриа, сургалт, сурталчилгаанд хамрагдсан иргэд, байгууллага:*

Арга хэмжээнүүдэд 1590 төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан, 439 хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, 259 малчин, 282 оюутан, 5275 сурагч, ажилгүй 761, нийт 8606 хүн хамрагдсан байна.

12. *Бичсэн мэдэгдэл, шаардлага, авсан хариу:*

Гэмт хэрэг, зөрчил үйлдэгдсэн, үйлдэгдэж болзошгүй шалтгаан нөхцөлийг арилгуулахаар 122 мэдэгдэл, 77 шаардлага хүргүүлж биелэлтийг 90 хувь хангасан бөгөөд 49 мэдэгдэл, шаардлагын биелэлтийг газар дээр нь шалгав.

Хугацаандаа хариу ирүүлээгүй 4 албан тушаалтныг тус бүр 100.000 төгрөгөөр торгож арга хэмжээ авсан.

13. Орон нутгийн “Саян”, “Дербес” телевизээр гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээ түүний үр дүнгийн талаар: телевизээр 80 удаагийн буюу 416 минутын мэдээ, мэдээллийг 161 удаагийн давталттай, радиогоор 32 удаагийн буюу 196 минутын мэдээ, мэдээллийг 64 удаагийн давталттай, “Баян-Өлгий Цагдаагийн газар” фейсбүүк болон www.bayan-ulgii.police.gov.mn цахим хуудсанд 227 удаагийн мэдээ, мэдээлэл байршуулж, нэвтрүүлэг, ярилцлага бэлтгэн хүргэсэн.

14. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 43 төрлийн 10757 ширхэг гарын авлага, зурагт хуудас, санамж, сэрэмжлүүлэг, зөвлөмжийг иргэд, олон нийтэд тарааж ажиллав.

15. Тус Цагдаагийн газраас төрийн 99, төрийн бус байгууллага 40, 52 аж ахуйн нэгжийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хамтран ажилласан.

16. Улсын хэмжээнд бүх төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулагдсан “Сар шинэ-2019”, хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулагдсан “Автомашин-2019”, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Нэг хором”, залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Залилан”, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр “Оюутан тээвэр”, “Тээврийн хэрэгслийн гадна талын гэрэлтүүлэг хэрэгсэл”, “Ачааны авто машин”, “Тусгай дуут, гэрлэн дохио”, “Хурд”, “Бяцхан зорчигч”, “Орон нутгийн зам хөдөлгөөний соёл 2019”, “Яараад яахав дээ”, “Улсын дугаар 2019”, хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Зөв тусгал”, “Хичээлийн шинэ жил 2019-2020”, “Хүүхэд” бусад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Байгалиа хамгаалъя”, “Бодис-2019”, “Нуугдмал”, “Эко-2019” зэрэг 19 удаагийн нэгдсэн арга хэмжээг тус тус төлөвлөгөөний дагуу зохион байгуулав.

17. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус 33 байгууллага, аж ахуйн нэгж, хүүхэд хамгаалал, хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх "School police" эргүүлийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр аймгийн төвийн ерөнхий боловсролын 13 сургуулийн захирал нартай хамтран ажиллах гэрээг 2019 оны 03 дугаар сарын 11-ний өдөр байгуулав.

Гэрээний дагуу төрийн болон төрийн бус байгууллага тус бүрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан албан тушаалтныг /орон тооны бус/ алба хаагч, ажилтныг нь дундаас томилуулан, тухайн байгууллага, аж ахуйн нэгжид чиглэсэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулан ажилласан.

18. Цагдаагийн газрын алба хаагчдыг аймгийн төв Өлгий суманд үйл ажиллагаа явуулдаг 76 аж ахуйн нэгж байгууллагыг цагдаагийн газрын даргын 2019 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/02 дугаар тушаалаар хариуцуулж 2019 оны эхний 9 сарын байдлаар давхардсан тоогоор 84 албан хаагч 309 аж ахуйн нэгж байгууллагад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тус бүр 9 удаа зохион байгуулснаар иргэдийн эрх зүйн мэдлэг дээшилж хуулиа сахин биелүүлэх сэтгэлгээ дээшилсэн болно.

19. 2018 онд хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг их бүртгэгдсэн тус аймгийн Баяннуур, Ногооннуур, Цэнгэл, Дэлүүн сумдад сумын ГХУСАЗСЗ-тэй хамтран “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт зөвлөгөөнийг зохион байгуулахаар төлөвлөсөн байсан. Төлөвлөгөөний дагуу хэлэлцүүлгийг 2019 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Баяннуур, 2019 оны 05 дугаар сарын 22-ны өдөр Цэнгэл, 2019 оны 05 дугаар сарын 24-ний өдөр Дэлүүн, 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдөр Ногооннуур суманд тус тус зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт сумдын Засаг дарга, ИТХ-ын дарга, сургуулийн захирал, нийгмийн ажилтан, багийн Засаг дарга, багийн Нийтийн хурлын дарга, багийн эмч, газар зохион байгуулагч болон иргэд, сурагчдын төлөөлөл болох нийт 287 хүн хамрагдсан.

Хэлэлцүүлгийг зохион байгуулахад шаардлагатай төсвийн төслийг сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газарт хүргүүлж, нийтдээ 1.250.000 төгрөг шийдвэрлүүлсэн.

20. Хүүхдийн эрхийг хамгаалах зорилгоор тус Цагдаагийн газраас Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгч, Аймгийн прокурор, Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, сум, багийн Засаг дарга, Өрхийн эрүүл мэндийн эмч, Нэгдсэн эмнэлэгийн төрөх тасгийн эмч, Улсын бүртгэлийн хэлтсийн хяналтын улсын байцаагч, мэргэжилтэн зэрэг нийт 86 албан хаагчийг

хамруулсан "Хүүхэд үрчлэхтэй холбоотой харилцаанд хүүхдийн эрхийг хамгаалах нь" сэдэвт сургалт, хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Хэлэлцүүлэгийн үеэр "Хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглахад хүлээлгэх эрүүгийн хариуцлага", "Хүүхэд үрчилсний, төрсний, нас барсны бүртгэл хийх явцад гарч байгаа зөрчил дутагдал, цаашид анхаарах асуудал" зэрэг сэдвээр илтгэл тавигдаж, харилцан мэдээлэл солилцсон бөгөөд сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулснаар сүүлийн үед хүүхдийг хуурамч бичиг баримт ашиглан хууль бусаар үрчилж авах гэмт хэрэг, зөрчил таслан зогсоогдох боломжтой болох юм. Сургалт, хэлэлцүүлэг, зөвлөгөөнөөс гаргасан дүгнэлт, санал, зөвлөмжийг судалж, хэрэгжүүлснээр тодорхой төрлийн гэмт хэрэг ялангуяа хүүхэд оролцсон гэмт хэрэг 10 нэгж буюу 52.3 хувиар буурахад нөлөөлөв.

21. Монгол Улсын Ерөнхийлөгчийн "Нээлттэй хаалганы өдөр"-ийг зохион байгуулж байх тухай 2007 оны 97 дугаар зарлигийн 1, 4 дүгээр заалтуудын хэрэгжилтийг хангах зорилгоор 2019 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр улсын хэмжээнд зохион явагдаж байгаа "Байгалиа хамгаалъя", "Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлье", "Бодис-2019", "Автомашин-2019" нэгдсэн арга хэмжээнүүдийг иргэдэд сурталчлах, энэ арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор аймгийнхаа төв талбайд "Нээлттэй хаалганы өдөр"-ийг зохион явуулав. Арга хэмжээний үеэр Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэргийн хор уршгийн талаар болон Залилах гэмт хэргийн түгээмэл үйлдэгдэж байгаа үйлдлийн аргыг иргэдэд мэдээлэх, таниулах, залилагч этгээдэд мөнгө, эд зүйлээ өгөхөөс татгалзах, хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх яриа таниулга хийсэн.

Мөн Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс зохион байгуулсан "Хууль сурталчлах өдөрлөг" арга хэмжээнд оролцож Цагдаагийн газрын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлах, цагдаагийн байгууллагын ажил, үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авч шуурхай шийдвэрлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулав.

22. Нийслэлийн цагдаагийн газраас бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн дагуу зохион байгуулж байгаа санал, санаачлагын хүрээнд орон нутгийн "Саян" телевиз болон "9-ийн мэдээ" радиотой хамтран долоо хоног бүрийн даваа, лхагва гараг бүр "Эрх зүйн хөтөч", "102 мэдээлж байна" нэвтрүүлэг, мэдээ, мэдээлэл бэлтгэн тасралтгүй хүргэж байна.

Нэвтрүүлэг, мэдээ, мэдээлэлд холбогдох хууль тогтоомж, журам, дүрэм, Цагдаагийн ерөнхий газар болон Цагдаагийн газраас зохион байгуулж байгаа ажил, арга хэмжээг тусган иргэд, олон нийтэд хүргэх, түгээх ажлыг зохион байгуулж байна.

Энэ оны эхний 9 сарын байдлаар 28 удаагийн нэвтрүүлэг, мэдээ, мэдээллийг түгээж ажилласнаар иргэдийн хууль эрх зүйн мэдлэг болон хуулиа сахин биелүүлэх сэтгэлгээ хандлага дээшлэх зэрэг эерэг өөрчлөлтүүд гарч байна.

2.5. Замын цагдаагийн албаны чиглэлээр

1. Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 146 дугаар тогтоолоор баталсан Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги (2012-2020 он), Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 163 дугаар тогтоолоор баталсан "Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр", Цагдаагийн газрын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 22 ажил, арга хэмжээ, Замын цагдаагийн тасгийн 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 40 төрлийн ажил, арга хэмжээний хэрэгжилтийг тус тус ханган ажиллаж байна.

2. Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн албанаас зохион явуулсан "Сар шинэ-гэрээгүй тээвэрлэлт", "Зорчигч-Ачаа тээвэр", "Хурд", "Тусгай дуут дохио", "Ачааны авто машины бүрэн бүтэн байдал", "Оюутан тээвэр-1" "Мотоцикл",

“Бяцхан зорчигч” “Улсын дугаар”, “Яараад яахав дээ”, “Мотоцикол”, “Хурд”, “Оюутан тээвэр-2”, “Ургац-2019”, “Хичээлийн шинэ жил”, “Дураараа биш дүрмээрээ” зэрэг нэгдсэн, “Гэрэлтүүлэг хэрэгсэл”, “Замын тэмдэг тэмдэглэлийн бүрэн бүтэн байдал”, “Улсын дугаар”, “Ачааны авто машин”, “Тээврийн хэрэгслийн өнгө үзэмж”, “Утаа”, “Ачаа тээвэрлэлт” зэрэг хэсэгчилсэн, нийт 23 арга хэмжээг төлөвлөгөө, удирдамжийн дагуу зохион байгуулав. Тухайлбал:

- Цагдаагийн ерөнхий газрын дарга, Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга нарын хамтран баталсан “Орон нутгийн зам-хөдөлгөөний соёл” урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг мөн Цагдаагийн ерөнхий газраас Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран энэ оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс мөн оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд “Орон нутгийн зам-хөдөлгөөний соёл” нэгдсэн арга хэмжээг үр дүнтэй зохион явуулах, сурталчлах талаар Цагдаагийн ерөнхий газрын даргаас 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 01/363 дугаартай ирүүлсэн “Үүрэг, ажлын чиглэл”-ийн хэрэгжилтийг тус тус хангах зорилгоор тус Цагдаагийн газраас “Орон нутгийн зам-хөдөлгөөний соёл” нэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэх 4 чиглэлийн 29 заалт бүхий ажлын төлөвлөгөөг аймгийн Засаг дарга, Цагдаагийн газрын дарга, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн даргаар батлуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Арга хэмжээний хүрээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулсан хяналт шалгалтын үр дүнд нийт 7935 зөрчил илрүүлж, зөрчил үйлдсэн 7935 хүнд 288.060.000 төгрөгний торгуулийн шийтгэл оногдуулав.

Үүнээс согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 265 зөрчил илрүүлж, 72 хүнийг 7-30 хоногоор баривчлах шийтгэлийг шүүхийн шийдвэрээр оногдуулан, 192 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилийн хугацаагаар хасч, 77.200.000 төгрөгний, эрхийн үнэмлэхгүйгээр тээврийн хэрэгсэл жолоодсон 218 хүнд 43.600.000 төгрөгний торгуулийн шийтгэл тус тус оногдуулсан.

Аймгийн төвийн жолооны сургуулиудад ABCDE ангилалд бүртгэгдсэн 892 иргэний материалыг хүлээн авч, шийдвэрлүүлсэн.

Эхний 9 сарын байдлаар хүний амь нас хохирсон хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 8 бүртгэгдсэн бол үүнийг өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад өссөн буурсан үзүүлэлтгүй, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчил өнгөрсөн мөн оны үеэс 33.3 хувиар буурсан эерэг үзүүлэлт гарсан.

Хөдөө орон нутагт үйлдэгдсэн зам тээврийн ослын улмаас 4 хүний амь нас эрсдэж, 9 хүн гэмтсэн.

3. “Газрын-од”, “Цэнгэл транс” ХХК-ны Өлгий-Улаанбаатар чиглэлд хүн тээвэрлэдэг хот хоорондын нийтийн тээврийн 45 айро автобусыг давхардсан тоогоор 8 удаа, аймгийн төвийн “Тасмал хоршоо”, “Жанарту” зэрэг аж ахуйн нэгжүүдийн нийтийн тээврийн 120 микробус, хот дотор хувиараа такси хийдэг 120 жолоочийг давхардсан тоогоор 6 удаа шалгаж тээврийн хэрэгслүүдийн бүрэн бүтэн байдлыг улирал тутам 1 удаа шалгаж, бүрэн бус тээврийн хэрэгсэлтэй хөдөлгөөнд оролцохгүй байх, хурд хэтрүүлэхгүй байх, хамгаалах бүс хэрэглэх, хүүхдийн суудлыг тогтоомол хэрэглэж хэвших, зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, зорчигчийн аюулгүй байдлыг хангах, замын хөдөлгөөний дүрмийг биелүүлж хөдөлгөөнд соёлтой оролцох, явган зорчигч нарт гарц дээр зам тавьж өгөх, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдалд анхаарч, хотын төвд болон орон нутгийн замд хурд хэтрүүлэхгүй зорчих зэрэг чиглэлээр урьдчилан сэргийлэх нэгдсэн сургалтанд нийт 1235 жолоочийг хамруулсан.

4. Өлгий-Улаанбаатар чиглэлийн Олон улсын болон улсын чанартай А0305, Өлгий-Цагааннуур чиглэлийн А0306 дугаартай авто замуудад өдөр бүр хөдөгөөнт эргүүл ажиллуулан орон нутгийн замд гарч буй тээврийн хэрэгслүүдийн жолооч, зорчигч нарт хурд хэтрүүлэхгүй байх, хамгаалах бүс, хамгаалах малгай тогтоомол хэрэглэж замын хөдөлгөөнд оролцох талаар яриа таниулга хийж ажиллаж байна.

Мөн тус аймгийн Цагааннуур тосгон дахь Замын цагдаагийн хяналтын постонд Цагааннуур тосгоны хэсгийн төлөөлөгч, цагдаа нарыг тогтмол ажиллуулж, постоор дамжин өнгөрч буй тээврийн хэрэгслүүдийн хөдөлгөөнд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулан дахин зөрчил гаргахгүй байх талаар 140 жолоочид яриа таниулга хийж ажиллав.

5. Тээврийн хэрэгсэл жолоодох эрхтэй иргэдээс хуучин үнэмлэх солиулахаар ирүүлсэн 5972 хүний материалыг хүлээн авч шинэ үнэмлэх олгов.

6. “Бяцхан зорчигч” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөртэй тохиолдуулан “Нэг ч хүүхдийг Зам тээврийн осолд өртүүлэхгүй баяраа тэмдэглэе” аяныг аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохицуулах зөвлөл, Өлгий сумын Засаг даргын тамгын газартай хамтран 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдөр тус аймгийн Өлгий хотод зохион байгууллаа.

Уг арга хэмжээний хүрээнд аймгийн төвийн авто замын хөдөлгөөнийг 10:00 цагаас 18:00 цагийн хооронд бүрэн хааж, иргэд жолооч нарт хүүхдийг зохиуралтын суудалд суулгаж тээвэрлэх, харгалзах хүнгүйгээр бага насны хүүхдийг замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх чиглэлээр хийгдсэн 1200 ширхэг санамж тарааж ажиллав.

7. “Яараад яахав дээ” аяны хүрээнд аймгийн төвийн төрийн болон төрийн бус байгууллагын 47 аж ахуйн нэгж байгууллага болон аймгийн 13 сумын төрийн болон төрийн бус байгууллагын давхардсан тоогоор 14650 иргэнд замын хөдөлгөөний дүрэм, хөдөлгөөнд оролцохдоо аюулгүй байдлыг хангаж оролцох, зам тээврийн осол хэргийн хор уршиг, хохиролын талаар, ач холбогдлын талаар нөлөөлийн арга хэмжээ авч яриа таниулга, ухуулга сурталчилгаа хийж ажилласан.

Арга хэмжээтэй уялдуулан аймгийн төвийн 4 цэгт замын хөдөлгөөний дүрэм, гэмт хэрэг, зөрчлийн тоо мэдээ, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажлыг сурталчилсан самбар байрлуулж, бүх сумуудын орох гарах цэгт аяныг сурталчилсан самбар байрлуулж, нийтдээ 9650 ширхэг, санамж, сэрэмжлүүлэг, зөвлөмж хүргүүлэв.

2.6. Нийтийн хэв журам хамгаалах чиглэлээр:

1. Аймгийн төвд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн криминалоги судалгаа, цахим зураглал, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж болзошгүй эмзэг цэгийн судалгаанд үндэслэн Цагдаагийн газрын даргын 2019 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/07 тоот тушаалаар эргүүлийн нэгдсэн байршилтийг шинэчилэн баталж, эргүүлийг гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг, хүн амын суурьшил, хөдөлгөөн ихтэй газруудад томилон ажиллуулж, тасгийн дарга, ахлах байцаагч нар хяналт тавин ажилласан.

2. Нийтийн хэв журам хамгаалах, замын цагдаагийн чиглэлээр 2019 оны эхний 9 сарын байдлаар давхардсан тоогоор 5808 алба хаагч 2880 цагийн хугацаанд эргүүлийн үүрэг гүйцэтгэж, эргүүлийн хяналтаар нийт 6346 тооны зөрчил илрүүлэн 9134 зөрчилд 198.185.500 төгрөгийн торгууль оногдуулж, 697 зөрчлийг шалгуулахаар эрх бүхий алба хаагчдад хүлээлгэн өгсөн байна.

3. 2019 оны мөн үеийн байдлаар цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүнийг 7 удаа, тасаг, албадыг хэсэгчилсэн байдлаар 13 удаа эргүүлд томилон ажиллуулж, аймгийн төвийн гудамж зам, гэр хорооллыг бүрэн хяналтад авч, нөхцөл байдлыг судлах, нийтийн хэв журам сахиулах ажлыг зохион байгуулан ажилласан.

Уг арга хэмжээний хүрээнд төрийн болон төрийн бус 51 байгууллага, аж ахуйн нэгжийн ажилчин, алба хаагчдад архины хор хөнөөл, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Зөрчлийн тухай хуулиудаар сургалт зохион байгуулсан ба аймгийн төвд архи согтууруулах ундаа худалдах, үйлчлэх үйл ажиллагаа эрхэлдэг 96 иргэнд хууль тогтоомж болон дээрх хөтөлбөр, аяны талаар сурталчилах ажлыг 2019 оны 03 дугаар сарын 12-ны өдөр зохион явуулсан.

4. Аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Үүнд:

“Гудамж талбай-эргүүлийн хяналт”, “Гэрэлтүүлэг-хяналтын камер”, “Хяналт шалгалт”, “Зочид буудал”, “Хулгайгаас сэргийлье”, “Цахим тоглоом”, “Хонхны баяр-хяналт шалгалт”, “Хичээлийн шинэ жил” зэрэг нийт 8 хэсэгчилсэн арга хэмжээг төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан бөгөөд нийт давхардсан тоогоор 120 алба хаагч 64 цагийн үүрэг гүйцэтгэж, зөрчил үйлдсэн 96 хүнд 10,850,000 төгрөгний торгуулийн шийтгэл оногдуулж, 31 зөрчлийг таслан зогсоож, ажилласны үр дүнд гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг өнгөрсөн жилийн мөн үеэс 4 нэгж буюу 18.1 хувиар буурхад нөлөөлөв.

5. Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий алба хаагчид иргэд, байгууллагаас ирүүлсэн зөрчлийн шинжтэй 1866 тооны гомдол, мэдээллийг шалгаж шийдвэрлэснээс 301 гомдол, мэдээлэлд зөрчлийн хэрэг нээж, 727 гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзан, 47 гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлж, 791 гомдол, мэдээллийг хялбаршуулсан журмаар шалгаж шийдвэрлэсэн. Зөрчлийн хэрэгт 143 хүнийг захиргааны журмаар баривчилж, 909 хүнд 204,675,000 төгрөгний торгууль оногдуулж, 240 хүний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нь хасаж шийдвэрлэсэн байна.

6. Шүүхээс хорих ялыг тэнсэн хянан харгалзсан, хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллагдсан, насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан нийт 21 ялтанд хяналт тавьж ажилласнаас хяналтын хугацаа дууссан 9 ялтны захиргааны хяналтыг зогсоож, одоо 12 ялтанд хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд нийтийн хэв журам хамгаалах тасгийн даргын зүгээс хяналтын материалтай сар бүр биечлэн танилцаж, үүрэг, чиглэл өгч, хэрэгжилтийг нь хангуулан ажилласан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/260, А/242 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, цагдаагийн байгууллагын хамтран ажиллах журам”-д заасны дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа нэгжгүй сумдад ажиллаж байгаа тус Цагдаагийн газрын сумдын хэсгийн мөрдөгч нараас 2019 оны мөн үеийн байдлаар нийтэд тустай ажил хийлгэх ялтай 6, эрх хасах ялтай 5, үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан 8 нийт 19 ялтанд хяналт тавьж, хяналтын мэдээг сар бүрийн 30-ны дотор аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт ирүүлэх ажлыг хэвшүүлсэн.

7. Тус Цагдаагийн газраас 2019 оны мөн үеийн байдлаар тус аймагт зохион байгуулагдсан урлаг, соёлын болон бусад арга хэмжээний 19 удаагийн хамгаалалтыг төлөвлөгөө, зураглалын дагуу зохион байгуулсан. Тухайлбал:

Тус аймгийн Ногооннуур сумын Цагааннуур тосгон, Улаанбайшинтын чиглэлд тарваган тахлын төст өвчний халдварын шинж илэрсэнтэй холбогдуулан хорио цээрийн дэглэм, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай аймгийн Засаг дарга, аймгийн онцгой комиссын шийдвэрийг үндэслэн Цагааннуур, Улаанбайшинт, Ногооннуур, Өлгий сумдын тодорхой чиглэлд 17 цэг байгуулан, цагдаагийн 22 алба хаагч 144 цагийн хугацаанд хорио цээрийн дэглэм тогтоож ажилласан.

Мөн 2019 оны 07 дугаар сарын 19-ний өдрөөс 2019 оны 07 дугаар сарын 24-ний хооронд Сагсай, Алтай сумдын 60 жилийн ой, “Байтемир” агсаны 75 жилийн ой, 2019 оны 07 дугаар сарын 27-28-ний өдрүүд “Баруун бүсийн зуны уралдаан”, 2019 оны 09 дүгээр сарын 14-15-ний өдрүүдэд Бугат сумын 60 жилийн ой, Алтанцөгц, Баяннуур, Булган, Толбо сумуудын бүрэн дунд сургуулиудын 60, 80 жилийн ой болон Алтай таван богд хайрханы тэнгэрийг тайх ёслол үйл ажиллагааны хамгаалалтуудыг тус тус гэмт хэрэг, зөрчилгүй зохион байгуулсан.

“Баруун бүсийн зуны уралдаан”-ны хамгаалалтыг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны 07 дугаар сарын 18-ний өдрийн А/172 дугаартай тушаалаар Цагдаагийн түр хүрээг тус аймгийн Бугат сумын нутаг дэвсгэрт байгуулж, Увс, Ховд аймаг дахь Цагдаагийн газраас тус бүр 20, нийт 40 алба хаагчийг нэмэлт хүчээр татан оролцуулж, зохион байгуулсан.

Дээрх ойн баяр, наадмын хамгаалалтанд давхардсан тоогоор нийт 318 алба хаагч 188 цаг, 41 тээврийн хэрэгсэлтэйгээр үүрэг гүйцэтгэсэн.

Баяр, ёслол, нийтээр тэмдэглэн өнгөрүүлэх баяр ёслолын өдрүүдэд цагдаагийн газрын алба хаагчдыг уртгасгасан цагаар эргүүлд томилон, гэмт хэрэг зөрчил үйлдэгдэж болзошгүй эмзэг цэгүүдэд тавих хяналтыг сайжруулан ажилласнаар баярын болон олон нийтийг хамарсан арга хэмжээний хугацаанд ямар нэгэн гэмт хэрэг бүртгэгдээгүй болно.

8. “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль”, “Авто тээврийн тухай” хууль, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай” хууль, “Аюултай ачаа техникийн ерөнхий шаардлага MNS 4978:2000, “Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4598:2003”, “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн үед мөрдөх аюулгүй ажиллагааны журам”, “Зам, тээвэр, хот байгуулалтын сайдын 2009 оны 188 дугаартай тушаалаар батлагдсан “Авто тээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журам”-уудын хэрэгжилтийг хангуулах, тэсэлгээний ажил, үйлчилгээ явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг шалган зааварчлах чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэж ажилласан. Үүнд:

- Тус аймгийн хэмжээнд уул, уурхай, ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашигладаг Цэнгэл сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах “СС Монголия”, “Ховд гол”-ын гянтболдын уурхай, үйл ажиллагаа нь түр зогссон боловч тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл хадгалагдаж байгаа Ногооннуур сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах “Юүшингминг” ХХК-ний “Дулаан хар”-ын уурхайн үйл ажиллагаанд 2019 оны 03 дугаар сарын 10, 2019 оны 08 дугаар сарын 31-ний өдөр тус тус хяналт шалгалт явуулсан.

Шалгалтаар Цэнгэл сумын “СС Монголия” ХХК-ний хадгалж буй агуулагад зохих журмын дагуу хадгалагдаж байсан ба ямар нэгэн зөрчил дутагдал илрээгүй.

9. Эрүүлжүүлэх, саатуулах байрны үйл ажиллагаанд ЦБҮАЖурам /код 629/, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/246 тоот тушаалаар батлагдсан “Баривчлах байрны дотоод журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайд, сангийн сайдын хамтарсан А/63, 70 дугаар тушаалаар батлагдсан “Баривчлагдсан этгээдийн баривчлах байранд байсан хугацааны шууд зардлын хэмжээг тооцох журам/ зэрэг журам, дүрмийг чанд мөрдөн ажиллаж байна.

2019 оны эхний 09 сарын байдлаар Эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байрны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгийн үйлчилгээний ерөнхий шаардлага MNS 5527:2014 стандарт, хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ MNS 5080:2001 стандартын шаардлага хангаж байгаа эсэх талаар аймгийн прокурорын байгууллагаас 16 удаа, цагдаагийн газрын дарга удирдлагууд 12 удаа, тус цагдаагийн газрын ёс журмын эргүүл болон эрх бүхий алба тушаалтнууд 146, дотоод хяналт шалгалт 64 удаа давхардсан тоогоор нийт 238 удаагийн хяналт шалгалт хийсэн ба энэ хугацаанд ямар нэгэн зөрчил илрээгүй болно.

2019 оны 09 дүгээр сарын мөн үеийн байдлаар тус цагдаагийн газрын эрүүлжүүлэх байранд 955, саатуулах байранд 104, захиргааны журмаар баривчлах шийтгэл эдлүүлэх байранд 188 хүнийг хүлээн авч, эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах шийтгэлийг эдлүүлсэн.

10. Шүүхийн байрны хамгаалалтанд харуулын 4 цагдаа нар томилгооны дагуу 24 цагаар үүрэг гүйцэтгэсэн ба тус хугацаанд шүүхээр үйлчлүүлсэн 3156 иргэнийг биеийн байцаалтыг шалгаж зохих журмын дагуу шүүхийн ажилтнуудтай уулзуулан, шүүхийн байрны аюулгүй байдлыг хангаж ажиллав.

Эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхэд 221, Иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхэд 679, Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 86, зөрчлийн 231 нийт 1217 удаагийн шүүх хуралдаанд шүүх,

шүүгчийн аюулгүй байдлыг хангаж, шүүн таслах ажиллагаа хэвийн явагдах нөхцөлийг бүрдүүлж, шүүх хуралдааны журам сахиулж ажилласан.

Хуяглан хүргэх ажиллагааг 53 удаа, 64 яллагдагчийг харгалзан гүйцэтгэхэд хууль журам зөрчсөн асуудал гараагүй, яллагдагч шүүгдэгчээс болон түүний өмгөөлөгчөөс ямар нэгэн гомдол санал ирээгүй.

2.7. Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны чиглэлээр:

1. Энэ оны эхний 9 сарын байдлаар гэмт хэрэг, зөрчлийн талаарх 2199 гомдол, мэдээлэл хүлээн авч бүртгэн шалгасан ба үүнээс 2188 гомдол мэдээллийг шийдвэрлэв.

Мөн нийт гомдол мэдээллээс гэмт хэргийн 391, зөрчлийн шинжтэй 1808 гомдол мэдээлэл эдэлж байгаа бөгөөд одоо үлдэгдэл 11 гомдол, мэдээлэл шалгагдаж байна.

Гэмт хэргийн шинжтэй 391 гомдол, мэдээллийн 390 шийдвэрлэсэн бөгөөд 85 хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналаар прокурорт хүргүүлж, 303 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 2 гомдлыг харъяаллын дагуу шилжүүлэн тус тус шийдвэрлэсэн байна.

Гэмт хэргийн шинжтэй 391 гомдол мэдээллийн 387 буюу 99.2 хувийг 5 хоногт шийдвэрлэж шалгуур үзүүлэлтийг ханган биелүүлсэн болно.

2. Цагдаагийн газарт 2019 оны эхний 9 сарын байдлаар нийт 233 гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдаж, гэмт хэргийн улмаас иргэд аж ахуйн нэгжид 714,2 сая төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад нийт учирсан хохирлын 340,6 сая төгрөг буюу 47,7 хувийг нөхөн төлүүлж, 134,6 сая төгрөгийн эд хөрөнгийг битүүмжилж ажилласан байна.

3. Гэмт хэргийн улмаас 11 хүн нас барж, 78 хүн хүнд, хөнгөн хэлбэрийн гэмтэл авч, нийт 191 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдаж үүнээс хүүхэд оролцсон гэмт хэрэг 10, эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэг 23, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 39, гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 18, бүлэглэн үйлдэгдсэн гэмт хэрэг 14 тус тус бүртгэгдсэн.

4. 2019 оны эхний 9 сарын байдлаар гэмт хэргийн бүртгэлийн санд /233 хүний/, яллах дүгнэлтээр, прокурорт хүргүүлэх бүртгэлд /154 хүний/, хэрэгсэхгүй болгосон хэргийн бүртгэлд /32 хүний/ сэжигтэний бүртгэлд /180 хүний/, хохирогч иргэн, байгууллагын бүртгэлд /230 хүний/, хохирлын бүртгэлийн санд /230 хүний/, таслан сэргийлэх арга хэмжээ авах санд /154 хүний/, яллагдагчийн бүртгэлд /134 хүний/, хохирол нөхөн төлүүлэлтийн бүртгэлд /185 хүний/, хөрөнгө битүүмжилсэн бүртгэлд /35 хүний/ мэдээллийг тус тус шивэгдсэн ба харъяа тасаг албадын дарга нар хянан баталгаажуулан Мэдээлэл судалгааны ахлах мэргэжилтэн хянаж төвлөрсөн тоо бүртгэлд авсан.

5. Хариуцсан нэгжийн хэмжээнд мэдээллийн сантай холбоотой журмын хэрэгжилтийг хангах, мэдээллийн нэгдсэн сантай холбоотой гарч байгаа зөрчлийн шалтгааныг тогтоож, гарсан зөрчлийг арилгуулах, цаашид зөрчил гаргуулахгүй байх талаар алба хаагч нарт 8 цагийн сургалт зохион байгуулж, сургалтанд 85 алба хаагч хамрагдав.

6. Мэдээллийн санд оруулбал зохих мэдээллийг оруулахгүй, хугацаа хоцроох, алдаатай буюу буруу мэдээлэл оруулсан 21 алба хаагчид Цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар интервалаар сарын үндсэн цалинг бууруулж олгож, хариуцлага тооцов.

7. Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд өдөр тутам шивэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл түүний шийдвэрлэлт, зөрчлийн хэргийн бүртгэл, шийдвэрлэлт, торгуулийн хуудас, хэрэг бүртгэлтийн болон эрүүгийн хэргийн маягт шивж оруулж буй алба хаагч нарын мэдээллийн санд гарч байгаа зөрчил дутагдал түүнд хийсэн үнэлэлт дүгнэлтийг үндэслэн Цагдаагийн газрын тасаг, хэсгийн дарга нарт 2019 оны 03 дугаар сарын 23-ны өдөр 9 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлж, биелэлт үр дүнг тооцон ажиллаж байна.

8. Цагдаагийн газрын Мэдээлэл судалгааны ахлах мэргэжилтэн, зөрчлийн тоо бүртгэгч нарт үүрэг, ажлын чиглэл өгч мэдээллийн сантай өдөр бүр танилцаж, 7 хоног бүрийн “Даваа”, “Лхагва” гарагт нийт бие бүрэлдэхүүнд мэдээлэл өгч, мэдээллийн сангийн ашиглалтыг Цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар сар бүр хэлэлцэж, мэдээллийн сангийн зөрчлийг арилгуулан ажиллаж байна.

9. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Монгол улсад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөх /код-701/ журам”, “Зөрчлийн тоо бүртгэл хөтлөх /код-702/ журам”-ын талаар Цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүнд 4 цагийн сургалт зохион явуулав.

10. Мэдээллийн сангаас сар бүр боловсруулан гаргасан “Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээ”, “Эрүүгийн хэргийн хөдөлгөөн шийдвэрлэлтийн мэдээ”, “Түдгэлзүүлсэн хэргийн мэдээ”-ний тайлангийн үзүүлэлтэнд сар бүр тулгалт хийж, сангийн зөрүүг арилгаж, аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын мэдээг дараа сарын 05-ны дотор хүснэгтээр гаргаж, Статистикийн болон Хууль эрх зүйн хэлтэст хүргүүлж байна.

11. Мэдээллийн сангийн бүрдлийг хангах, хэвшүүлэх, ашиглах, мэдээллийн зөрүүтэй байдал үүсгэх зөрчил гаргуулахгүй тулд сум дахь хэсгийн төлөөлөгч нараас цаасан суурьтай мэдээ, тайлан авах үед сантай давхар тулгалт хийж ажиллаж байна.

12. 2019 оны эхний 09 сарын байдлаар 10158 нийт зөрчил бүртгэгдэж зөрчилд холбоотой 954 хүн саатуулагдаж, 167 хүн шүүхээр баривчлагдаж, 9626 хүнд нийт 389175,5 мянган төгрөгийн торгуулийн шийтгэл оногдуулж, 232 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасав.

13. Зөвшөөрөлгүй цэгт согтууруулах ундаа худалдан борлуулсан, цаг хэтрүүлэн ажилласан аж ахуйн нэгж, хувь хүнээс нийт 185 литр согтууруулах ундаан, Тамхины хяналтын тухай хууль зөрчсөн 1750 ширхэг тамхи тус тус хураан авч шийдвэрлэсэн.

14. Улсын бүртгэлийн хэлтсээс овог, нэр өөрчлөх, хүүхэд үрчлэх гэх зэргээр ирүүлсэн нийтдээ 250 хүн, хуулийн этгээдийн материалыг, ард иргэдээс ирүүлсэн 1879 материалыг тус тус хүлээн авч нэгдсэн сүлжээгээр МДШШУА-д хүргүүлэв.

Мөн хэрэг бүртгэгч, мөрдөгч, эрүүгийн мөрдөгч нарын өгсөн 239 хүн, хуулийн этгээдийн ял шалгах хуудсыг холбогдох газарт хүргүүлэв.

15. Цагдаагийн газрын тасгийн дарга нарт Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны холбогдох журам, мэдээллийн сангийн ашиглалтыг сайжруулах талаар 8 заалт бүхий зааварчилга өгч хэрэгжилтийг хангуулсан.

2.8 Дотоодын цэргийн тусгай /гэрээт/ салааны үйл ажиллагааны чиглэлээр:

1. Улсын онц чухал объектын хамгаалалтыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагч, Дотоодын цэргийн штабын дарга, Цагдаагийн газрын дарга нарын нарын өгсөн үүрэг, ажлын чиглэлүүдийн дагуу зохих түвшинд зохион байгуулан ажиллаж байна.

2. Цагааннуурын худалдааны чөлөөт бүс нь байгуулагдсанаас хойш одоог хүртэл үндсэн ажлын чиглэлээр үйл ажиллагаа явуулаагүй байгаа.

3. Тус салаа нь “Цагааннуур” тосгон дахь чөлөөт бүс УОЧО-ын харуул хамгаалалтыг хариуцаж, харуулын дарга нар 3 ээлж, харуулчин ахлагч нар 3 ээлжээр долоо хоногоор чөлөөт бүсийн худалдааны төвийн офиссын төв байр, зочид буудал, 10 склад агуулах, “VIP SHOP” дэлгүүр, харуулын 5 шалган нэвтрүүлэх байр, 16,000 метрийн тойрог бүхий төмөр торон хашааг хяналтанд авч харуулын үүргээ хэвийн гүйцэтгэж ажиллаж байна.

4. Тайлангийн хугацаанд улсын онц чухал объектын хамгаалалтад 3 харуулын дарга, 11 ахлагч нийт давхардсан тоогоор 2683 цагийн үүрэг гүйцэтгэж, объектод байнгын үнэмлэхээр нэвтэрсэн иргэн 29, гаднаас нэвтэрсэн иргэн 22, 10 тээврийн

хэрэгслийг зохих журмын дагуу шалган нэвтрүүлж, 10924 удаагийн бусад хөдөлгөөнийг бүртгэж нийт 21670 удаагийн хөдөлгөөнд хяналт тавьж, холбогдох хууль тогтоомж, журам, дүрмийн хэрэгжилтийг хангуулав.

5. Объектын хамгаалалтын талаарх нөхцөл байдлын мэдээг Цагдаагийн ерөнхий газрын шуурхай удирдлагын төвд өдөрт 2 удаа, Цагдаагийн газрын жижүүрийн шуурхай албанд цаг тутам өгч, харуулчин ахлагч нар харуулын даргад нөхцөл байдлын мэдээг 30 минут тутамд тасралтгүй дамжуулан ажиллав.

6. Тусгай салаа /гэрээт/-ны албан хаагчид харуул хамгаалалтын үүргээ хуулийн хүрээнд зохих төвшинд гүйцэтгэж, долоо хоногийн Баасан гараг бүр харуулын ээлж хүлээлцэж, үүрэг гүйцэтгэх ээлж, харуулаас бууж байгаа алба хаагч нарт ажлын үүрэг чиглэл өгч, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Сургалт, соён гэгээрүүлэх ажлын чиглэлээр:

7. Дотоодын цэргийн штабын даргын 2018 оны А/25 тоот тушаалын хэрэгжилтийг хангах, алба хаагчдад хууль, эрх зүйн болон цэргийн хэргийн мэдлэг дадлага, чадварыг эзэмшүүлэх, мэргэшүүлэх, салааны жигдрэлтийг хангах, тавигдсан зорилтыг хангах, зорилтыг биелүүлэх, бие бялдар, сэтгэл зүйн өндөр чадварыг эзэмшүүлэх, албаны сургалтыг чанартай зохион байгуулах зорилгоор 2019 оны сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан 02 дугаар улиралд зохин явагдах ажлын байрны сургалтын хөтөлбөрийн дагуу офицер, ахлагч бүрэлдэхүүнд нийт 107 удаа 158 цагийн лекц болон дадлага, семинарын сургалтыг зохион явуулж ажилласан.

Улаанбаатар хотод 2019 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс 29-ний өдрийн хооронд зохион байгуулагдсан Дотоодын цэргийн байгууллагын удирдах ажилтны сургалт, зөвлөгөөнд тусгай салааны захирагч хамрагдаж мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн.

Тусгай салааны харуулын дарга, дэслэгч Ч.Батчөдөр 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөс 2019 оны 06 дугаар сарын 04-ний өдөр хүртэл Дотоод хэргийн их сургуулийн Ахлагчийн сургуулийн Цагдаагийн албаны “Офицер” бэлтгэх 1 сарын сургалтад суралцаж албан тушаалын мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн.

Дотоодын цэргийн байгууллагын ахлагч бүрэлдэхүүний дунд зохион байгуулсан “Шилдэг харуулчин 2019” тэмцэнд тус салааны ахлагч нар амжилттай оролцсон.

Дотоодын цэргийн штабын 2019 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 2/928 дугаар албан бичгээр ирүүлсэн Дотоодын цэргийн анги, байгууллагын хэмжээнд зохион байгуулагдах “Стрессгүй өдөр” бие даасан өдөрлөгийн арга хэмжээний удирдамжийн дагуу салбар “Удирдамж төлөвлөгөө” гаргаж, 2019 оны 08 дугаар сарын 15-ны өдрөөс 2019 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн хооронд тусгай салааны алба хаагчид болон гэр бүлийн гишүүдийг хамруулан “Стрессгүй өдөр” бие даасан өдөрлөгийг зохион байгуулсан болно.

Алба хаагчдын ур чадварыг дээшлүүлэх, бие бялдарыг чийрэгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор тусгай салааны алба хаагч нарт 7 хоног бүрийн Даваа, Баасан гарагт жагсаалын бэлтгэл, Мягмар, Пүрэв гарагт бие бялдрын бэлтгэл сургуулилт, хүчний дасгалуудыг тогтмол хийлгэж хэвшүүлсэн.

Тус цагдаагийн газраас баруун таван аймгийн цагдаагийн газруудаас үлгэр жишээч 5 айлыг сонгон үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэн, ажил амьдралаа тэгшхэн авч яваа алба хаагчийн гэр бүлийг онцолж тус цагдаагийн газар дахь Дотоодын цэргийн салааны захирагчийн гэр бүлийг шалгаруулж, алба хаагчдын харилцааны болон биеэ авч явах соёлыг төлөвшүүлэх зорилгоор “Үлгэр жишээч гэр бүл” нэвтрүүлгийг бэлтгэж, олон нийтэд болон алба хаагч нарт сурталчлах ажлыг зохион байгуулж байна.

8. Авлигын эсрэг хууль тогтоомж, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2019 онд дэвшүүлсэн зорилт, цагдаа, дотоодын цэргийн алба хаагчийн сахилгын болон ёс зүйн дүрэм, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг албан хаагчдад сурталчлан таниулах, тэдний бүтээлч ажиллагааг дэмжин урамшуулах

замаар авлигын гэмт хэрэг, авлига, ашиг сонирхлын болон сахилга, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх эерэг хандлага, ёс суртахуун төлөвшүүлэх зорилгоор 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдөр тусгай салаа харуулын дарга, харуулчин ахлагч нарын дунд “Илтгэлийн уралдаан” зохион байгуулав.

Гурав: Дүгнэлт

1. Тус Цагдаагийн газар тайлангийн хугацаанд хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргээ шалгуур үзүүлэлтийн түвшинд гүйцэтгэж ажилласан.

2. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2019 онд хэрэгжилтийг хангах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, биелэлт үр дүнг тооцох 70 баримт бичгийн хэрэгжилтэнд хяналт шинжилгээ хийж, биелэлт үр дүнг тогтоосон хугацаанд тайлагнасан.

3. Цагдаагийн газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/37 дугаар тушаалаар Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх салбар комиссыг 10 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй байгуулж, бэлтгэл ажлыг хангах 17 заалт бүхий ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг 97.3 хувьтай хангаж ажилласан.

4. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас 2019 оны эхний 9 сарын байдлаар гэмт хэрэг, зөрчлийн талаарх 2199 гомдол, мэдээлэл хүлээн авч бүртгэн шалгасан ба үүнээс 2188 гомдол мэдээлэл буюу 99.5 хувийг шийдвэрлэсэн.

Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 387 буюу 98.9 хувийг шийдвэрлэсэн бөгөөд үүнийг өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад шийдвэрлэлт 1.2 хувиар өссөн үзүүлэлттэй гарсан нь гомдол мэдээллийн шийдвэрлэлтэнд тавих хяналт дээшилж, мэдээллийн сангийн ашиглалт сайжирсантай холбоотой гэж дүгнэхээр байна.

Мөн зөрчлийн шинжтэй 1808 гомдол мэдээллийн 92.8 хувийг хуулийн анхны хугацаанд шалгаж шийдвэрлэсэн ба шийдвэрлэлтийг өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 18.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

5. Гэмт хэргийн илрүүлэлт 66.0 хувьтай байгаа бөгөөд өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 0.2 хувиар өссөн байна.

6. Цагдаагийн газрын даргын 2019 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/07 тоот тушаалаар эргүүлийн нэгдсэн байршилтыг шинэчлэн баталж, эргүүлийг гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг, хүн амын суурьшил, хөдөлгөөн ихтэй газруудад томилон ажиллуулж, тасгийн дарга, ахлах байцаагч нар хяналт тавин ажилласнаар зөрчлийн илрүүлэлт 2513 зөрчил буюу 24.8 хувиар өссөн нь гэмт хэргийг зөрчлийн шатан илрүүлэх ажилд ахиц гарсныг харуулж байна.

7. Мөн нийт бүртгэгдэн гэмт хэргийн 50-60 хувийг эзэлдэг хүний халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 14 хэргээр буюу 16.8 хувиар, хулгайлах гэмт хэрэг 18 хэргээр буюу 33.3 хувиар тус тус буурсан эерэг үзүүлэлт гарсан.

8. “Баруун бүсийн зуны уралдаан”, Алтай таван богд хайрханы тэнгэрийг тайх үйл ажиллагааны хамгаалалтыг төлөвлөгөө, зураглалын дагуу гэмт хэрэг, зөрчилгүй зохион байгуулсан болно.

ЦАГДААГИЙН ГАЗАР